




МОНГОЛ КОНСЕРВАТИВ НАМ

МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТ
УХА0122
№ 80-
20 . . . он . . . сар

БОДЛОГЫН ХУВЬСГАЛ-(5+3) /2016-2020/

(МОНГОЛ КОНСЕРВАТИВ НАМЫН 2016 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР)



Улаанбаатар хот
2016 он

н
И ГАЗАР

?
27
өдөр

БОДЛОГЫН ХУВЬСГАЛ -(5+3)

/2016-2020/

(Монгол Консерватив намийн 2016 оны УИХ-ын сонгуульд оролцох мэрийн хөтөлбөр)

Уриа: ...Бид бодлогын хувьсгал хийнэ..,

- "СЭРСЭН МОНГОЛ" ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
- "САХИЛГАТАЙ МОНГОЛ" УЛС ТӨРИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
- "САРУУЛ МОНГОЛ" МЭДЛЭГИЙН ХУВЬСГАЛ
- "САНХҮҮТЭЙ МОНГОЛ" ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО ХУВЬСГАЛ
- "СЭТГЭЛТЭЙ МОНГОЛ" НИЙГМИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ




Энэхүү баримт бичгийг ашиг олох зорилгогүйгээр бүтнээр болон хэсэгчлэн хувилах, нийтлэх, цахим хэлбэрт оруулах бусад ямар нэг хэлбэрээр эх сурвалжийг заан ашиглах нь нээлттэй. Гэхдээ зөвхөн зохиогчийн зөвшөөрөлтэйгээр ашиглана.

БОДЛОГЫН ХУВЬСГАЛ -(5+3)**МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА**

...Бид бодлогын хувьсгал хийнэ..,

ТОТГО УГ

1. УРИА
2. АЛСЫН ХАРАА
3. ЭРХЭМ ЗОРИЛГО
4. ҮНЭТ ЗҮЙЛ
5. ИТГЭЛ ҮНЭМШИЛ
6. ҮЗЭЛ БАРИМТЛАЛ
7. ЗАРЧИМ
8. ШИНЭ ҮНДСЭН ХУУЛЬ
9. АЛСЫН ХАРААГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИД
10. АХ ДҮҮГИЙН ХАРИЛЦАА
11. "СЭРСЭН МОНГОЛ" ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
12. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГО
13. ГЕОПОЛИТИКИЙН БОДЛОГО
14. ЭРЧИМ ХҮЧНИЙ БОДЛОГО
15. ДЭД БҮТЦИЙН БОДЛОГО
16. "САРУУЛ МОНГОЛ" ШИНЖЛЭХ ИХААН, ИННОВАЦЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО
17. "САНХҮҮТЭЙ МОНГОЛ" ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО
18. "СЭТГЭЛТЭЙ МОНГОЛ" НИЙГМИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
19. "САХИЛГАТАЙ МОНГОЛ" УЛС ТӨРИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ
20. "САХИЛГАТАЙ МОНГОЛ" АРДЧИЛАЛЫГ ЗАСАГ ХУВЬСГАЛ
21. ТӨРИЙН ДЭЭД ХҮН БЭЛТГЭХ БОДЛОГО



МОНГОЛ КОНСЕРВАТИВ НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

“Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой ёсч байгаа эдийн засгийн ~~өдөр~~ олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, унаган байгаль, экологийн тогтвортой байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно.” гэсэн Монгол улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг урьдатгал болгон боловсруулсан болно.

Монгол консерватив намын 2016 оны УИХ-ын сонгуулыд оролцох мөрийн хөтөлбөр “ҮНДЭСНИЙ БОДЛОГЫН ХУВЬСГАЛ -(5+3) /2016-2020”-г боловсруулахдаа дараах зарчмууд дээр сууриссан болно.

- Үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;
- Нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;
- Терийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх;
- Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- Нөөц бололцоонд үндэслэсэн байх;
- Ил тод, нээлттэй байх;
- Олон нийтийн оролцоог хангасан байх.

1. УРИА

...Маргаашийн төлөө сэргээе..,

2. АЛСЫН ХАРАА

Үнэт зүйлээ залгамжилсан “САХИЛГАТАЙ” МОНГОЛ



3. ЭРХЭМ ЗОРИЛГО

Хариуцлагатай засаг төр, төрийн зохицуулалт бүхий нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засагт түшиглэсэн, хувийн болон нийтлэг эрх ашгийг зохицстойгоор хангасан, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх хүмүүнлэг, ардчилсан, иргэний нийгэм.

4. ҮНЭТ ЗҮЙЛ

Монгол Үндэстэн
Монгол хүний эрдэм

“Нүүдэлчин язгуурт Монгол үндэстэн”
“Хүн төрөлхтөнд оюун соёлоо өвлүүлсэн Монгол хүний эрдэм”

Монгол хэл

“Нэн эртнийх гэж олон улсын эрдэмтэд хүлээн зөвшөөрсэн Монгол хэл бичиг”

Монголын газар шороо

“Хэн ч гүйсан өгөхгүй үе дамжсан тангарагтай Монголын газар шороо”

Төрөлхийн тэнгэрлэг байдал

“Байгальтайгаа зохицож амьдрах үүн ухаант тэнгэрлэг үзэл”

Түүхийн санамжит гэрээслэл

“Могойг гурав хуваахад гүрвэлийн чинээ
Монголыг араав хуваахад гүрний чинээ”

Төрийн хар хайрцгийн бодлого
Тусгаар тогтнол

“Төрийн ЦААЗ – ЭРХЭМЖ-ийн бодлого”

Дэлхийг төвшитгэж явсан их амжилт "Хүннү гүрэн их Чингисийн эзэнт их үндэсний аудитын I дэлхийг

төвшитгэж явсан түүхэн замнал"

УХА0122

Ахан дүүсэг андын харилцаа
Монгол хүний мөн чанар

"Ахан дүүсэг андын "ЗА" гэх андгайгаар"
"Монгол хүний хүн чанар, зөн чанар, мөн чанар"

№ 803

Ардчиллын үнэт зүйлс ч Монголчуудын үнэт зүйл

(Ардчиллыг тухайн орон өөрийн үнэт уламжлал онцлогт тохируулан хэрэглэх хэрэгтэй.)

20.16. он 04. сар 2016

Чөлөөт байдал

Хүний эрх, үүрэг

Шударга ёс

Эв нэгдэл

Тэнцүү байдал

Хувийн өмч

Иргэний нийгэм

Иргэдийн оролцоо

Хамтын зах зээл

Хуулийн засаглал

Улс төрийн зөвшилцөл

Чөлөөт сонгууль

5. ИТГЭЛ ҮНЭМШИЛ

Монгол хүний дээр юу ч бүтээгдээгүй, Монгол хүний дор юу ч бүтээгдээгүй учир Монгол хүний тэнгэрлэг байдал үүрдийн дээд зарчим байх болно.

6. БАРИМТЛАЛ

Даяарчлалд уусахгүй үлдэх ганц арга бол тухайн үндэстэн оюуны дархлаатай байх юм. Монголчууд үнэ цэнэтэй зүйлээ залгамжлах үзэл бол дэлхийн хараатай Монголын хүсэл болон төсөөлөл гэж ойлгох хэрэгтэй.

"Тэнгэрийн дор газар, газар дээр ганц эзэн байна. Тэр нь Монголчууд байна" гэж хүсч, төсөөлсөн 13 дугаар зууны Монголын үнэт зүйлийг нойрноос нь сэрээж, Монгол үндэстний үнэт уламжлалыг амьдрал, хөгжил болгох гэж харийн үзэл баримтлалыг даган баясагчдын эсрэг Монгол үнэ цэнэтэй бүхнээ залгамжлах үзэл амилсан.

Үнэ цэнэтэй зүйлээ залгамжлах гэдэг үзэл нь хүн төрөлхтний төрийн мэдлэгийн үнэт зүйл юм. Зөвхөн уламжлал биш гэдгийг ойлгох хэрэгтэй. Монгол үндэстний итгэл үнэмшил бол Монголын үнэ цэнэтэй зүйлээ залгамлаж үзэл байна.

Үндэсний үнэ цэнэтэй зүйлээ залгамлаж үзэл бол түүхийнхээ хамгийн үнэт зүйлийг (Best Traditional) хөгжилдөө авч хэрэглэн явахыг хэлдэг.

Монголын түүхийн хамгийн үнэт уламжлал бол XIII-XIV зууны хүн төрөлхтнийг төвшитгэх бодлого явуулж байсан үе юм. Монголын үнэ цэнэтэй зүйлээ залгамлаж үзэл бол Монгол Үндэстний хүн төрөлхтний хөгжил болон энх тайвныг авч явж байсан үнэт уламжлалын улс төр, нийгэм, эдийн засаг, үндэсний эрх ашиг болон гадаад бодлогын илэрхийлэл юм.

Дэлхийг жижигрүүлдэг агуу хүсэл болон төсөөллийг уриалан дуудаж сэргээсэн цагт л Монголд үнэт зүйлээ залгамжлах үзэл амилж, Монгол хөгжилтэй, бахархалтай, омогтой, итгэлтэй, амьдрал утга учиртай болно.

7. ЗАРЧИМ

Нэг ч Монгол хүнийг төрийн хамгаалалтын гадна байлгахгүй байх

Монгол хүн хаана амьдарсан ч эрх чөлөө болон баялагийн гадна үлдэхгүй байх.

8. ШИНЭ ҮНДСЭН ХУУЛЬ

Монголын Улсын үндсэн хуулийг Агуу Монгол Үндэстний хүсэл болон төсөөлөлд нийцүүлэн Монгол хүн Монгол нутагт номер нэг байх үзлийг суулган, шинэчлэн боловсруулж, үндсэн хуулийн заалтууд жирийн иргэний амьдралд баталгаажих боломжийг бүрдүүлнэ.

9. АЛСЫН ХАРААГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИД

- Монгол Улсын Ерөнхийлөгч
- Улсын Их Хурал, Үндэсний мэргэжлийн засгийн газар
- Монгол Консерватив нам
- Мэдлэг, эрдэмтэй, эх оронч, хөдөлмөрч иргэн
- Монгол гаралтай дэлхийгээр тархан суурьшсан оюунлаг эрдэмтэй хүмүүс
- Дэлхийн соруудыг дайчлан ажиллуулж чадах Монгол удирдагч
- Үнэ цэнэтэй зүйлээ залгамжлах хүсэлтэй бүх хүмүүс
- Чин шударга иргэний оролцоо

Дээрхи хүмүүс нь өөрийн бүх амьдралаа Монголын төлөө харамгуй зориулах болохоос биш хувийн амьдралын төлөө тарчлан зовох шаардлагагүй тул Монголын үндэсний үнэт зүйлийн нэг учраас амьдралын баталгаа аюулгүй байх ёстой.

10. АХ ДҮҮГИЙН ХАРИЛЦАА

Монгол хүний зөвүүд хүн төрөлхтний зөвүүдтэй адил эрхэмлэн дээдлэгдсэнээр Монгол хүний эрх чөлөө тэнцүү байдал, шударга ёс болон андын харилцаа дархлаажих болно.

“Чингис хааны дэлхийг төвшитгэх агуу үйл хэргийг харвал цөөн хүн амтай ч үндэстнээрээ андын зохион байгуулалтанд орж, аравт, зуут, мянгатаар хуваагдаж өөрөөсөө үлэмж их хүн амтай улсуудыг захиргаандаа нэгтгэж дэлхийд олон зуун жил амар амгаланг тогтоож, хүмүүнлэг, хамгийн боловсронгуй хуулийн тогтолцоог бүрдүүлж чаддагийн баталгаа юм”.

11. “СЭРСЭН МОНГОЛ” ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Уриа: Үндэсний засаалалын хувьсаял хийнэ. Монголын төр данхааас илүү хүчтэй төрийн чухалчилна. Хамтаараа сайхан амьдрах вэж төр оршин тоогтнодог болохоос ядуу байлаах аэж төр орших ёсгүй. Төр хэдхэн хүний сайхан амьдрах хэрээсэл биш, нийтээрээ сайхан амьдрах тухай ойлголт..,

Засаглалын зарчмуудыг баримтлана.

- Төрийн бодлогын залгамж чанар, салбар хоорондын уялдааг сайжруулж, тогтвортой байдлыг хангах;
- Хууль дээдлэх зарчмыг чанд мөрдөх;
- Удирдлагын ил тод байдлыг хангах;
- Төвлөрлийг сааруулж, шийдвэр гаргахад бүх талын оролцоог хангах;
- Төрийн албаны ёс зүйг чанд мөрдүүлж, авилгыг арилгах.

11.1 ДАНХАР, СУЛЬДААТАЙ ТӨРИЙГ ЗАСАХ БОДЛОГО

Данхар төрийг засахгүй бол дэмийрэл нь ирээдүйд халтай..,

Барууныхан өөрсдийн хэзээ ч мөрдөж байгаагүй (магадгүй хэзээ ч мөрдөхгүй) чөлөөт худалдаа, юунд ч оролцдоггүй төрийн онолыг хөгжлийн эрэмбээрээ хоцорч яваа улсуудад тулгасан ашигладаг ашиглагч бодлогыг таслан зогсоон.

Гурван сая хүн амтай манай орны хувьд Хятадын хэмжээний засгийн аппараттай байх нь утгагүй. Тиймээс төрийн 18 яамдыг татан буулгана.

Татвар төлөгчдийн мэнгөөр үрэлгэн зардал гаргаж, данхар төрийг санхүүжүүлж буйг таслан зогсоож, татварын мөнгийг бүтээн байгуулалт руу чиглүүлнэ.

Гэвч Баруун Европын дайны нутаг дэвсгэртэй, асар их байгалийн баялагтай, бүх талаар нь хааж боогоод байх чадвартай хоёр аварга хөрштэй орны төр жижиг, арлын орныхоос отг өөр байх ёстой нь ойлгомжтой! Монголд яагаад гадаадын туршлага тэр бүр шингэдэггүй, яагаад бидний өвөг дээдэс хүчтэй үедээ хүчирхэг төртэй байсны шалтгаан нь энэ.

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН

УХА0122

№ ... 803

20 .16 он .04 сар .87

11.2 ЦОМХОН, ХҮЧТЭЙ ТӨРИЙГ БАЙГУУЛАХ БОДЛОГО

Төр хүчтэй байх, төрийн оролцоо хоёр асар ялгаатай ойлголт. Төрийн хэрхэн төөвхнүүлэх урлаг үндэсний хүч чадлын нэн чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

Тогтвортой засаглал

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг амжилттай хэрэгжүүлэх нэг үндсэн нөхцөл нь тогтвортой засаглал мөн. Тогтвортой засаглалыг хангах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал болон гадаад бодлогын үзэл баримтлал, батлан хамгаалах номлолын дагуу улсын тусгаар тогтол, аюулгүй байдлыг баталгаажуулж, батлан хамгаалах чадавхийг бэхжүүлж, гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлж, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тогтвортой хөгжлийг бататгахад оршино.

Улс төрийн гурван журмыг Монголын төрд хэлбэршүүлнэ. Эрх мэдэл төвлөрүүлж, олон жилийн дураараа авирлах төөрөгдлийг арилгаж, иргэний эрх хуулийн хүрээнд хүчтэй байх боломжийг нээнэ. Хуулиар нийгмийн дүрмийг тогтоон барих бодлогыг туштай хэрэгжүүлнэ. Хуулийн өмнө нийгмийн эмх журам төвшитгэдэг тогтолцоог бий болгоно. Эрх мэдэлтнүүд болон албан тушаалтууд хариуцлагаа хүлээдэг хуулийн, иргэдийн хяналтын тогтолцоог бий болгоно.

Үндэсний мэргэжлийн засгийн газрыг 9 яамтай үйл ажиллагаа явуулж засгийн газрын одоогийн байгууламжийг цомхотгоно.

1. Батлан хамгаалах, спортын яам
2. Аж үйлдвэр, худалдааны яам
3. Сангын яам
4. Гадаад харилцааны яам
5. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
6. Хууль зүй, дотоод хэргийн яам
7. Эрчим хүч, дэд бүтэц, харилцаа холбооны яам
8. Нийгмийн хамгаалал, эрүүл мэндийг хамгаалахын яам
9. Залуучуудын яам

12. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГО

Уриа: Хамгаалттай бодлогыг хэрэгжүүлнэ. Үндэсний аюулгүй байдлын хавчигдсан бодлогоос гарч байж хүчирхэг бодлого хэрэгжүүлнэ. Хараат, чөдөрлөгдсөн бодлого бол биднийг хүчтэй оршихыг үгүйсгэсэн хэрэг...

Зарчим баримтална

Үндэсний эрх ашгийг түрүүнд тавих

Найрсаг байх

Холч байх

Хараат бус байх

Шударга байх

Бие даасан байх

ОУ-ын конвенци, хууль баримтлах

Зөвшөөрөхгүй...

Монгол хүний оюуны дархлааг устгах оюуны террорист үйл ажиллагаа явуулж буй аливаа **АЗАР** хэлбэр, ходоод, хоол хүнсээр дамжуулж явуулах бодлого, олон улсын гэрээ конвенци, хууль эрх зүйг үл хүндэтгэх хандлагыг, Монгол хүнийг хүчгүй сүл дорой байлгах бодлогыг..,

Ингэж шийднэ. Монгол үндэсний язгуур эрх ашгаар л гадаад бодлогын зорилтоо тодорхойлно. Монгол хүний үнэт зүйлийг хамгаалсан бодлого хэрэгжүүлнэ. Монгол улс тусгаар тогтносон, бие даасан энх тайванч дипломат бодлого эрс хэлбэрэлтгүй хэрэгжүүлнэ. **өдөр**

Тус бодлогын хол ч бол Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалж, дэлхийн энх тайванг хамгаалан, хамтаар хөгжих бодлого байх ёстой.

“Хуульд захирагдах нь” Монгол үндэстний тусгаар тогтнол, тогтвортой байдал болоод хөгжил цэцэглэлтийн үндэс гэдгийг баримтална.

Монгол Үндэстэн дипломат бодлого, харилцааны хувьд эртний үнэт уламжлалтай. Монголын үндэсний аюулгүй байдал гадаад бодлогоо үнэт уламжлалдаа тулгуурлан явуулна.

Ард түмний эсрэг гадны ил далд бодлогуудыг таслан зогсоож, гаднаас нөлөөлөх боломжийг хязгаарлах замаар Үндэстний бие даасан холч бодлого хэрэгжүүлнэ. Үндэсний аюулгүй байдал нь үндэсний эрх ашгийн баталгаа мөн бөгөөд энэ хүрээнд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан хэм хэмжээ, чиглэлүүдийг чанд баримтална. Үүнд:

- Монгол Улсын оршин тогтнолын аюулгүй байдал
- Нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал
- Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал
- Эдийн засгийн аюулгүй байдал
- Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал
- Мэдээллийн аюулгүй байдал
- Монгол соёл иргэншилийн аюулгүй байдал
- Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал
- Экологийн аюулгүй байдал
- Хүнсний аюулгүй байдал



Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн.” гэж заасныг баримтлан хэрэгжүүлнэ. ОХУ, БНХАУ-тай холч хараатай стратегийн түншлэлийн харилцааг хадгалах бодлого, сайн хөршийн харилцан итгэлцлэлийн найрсаг харилцаагаа хадгалах бодлого явуулна.

Монголын батлан хамгаалах салбарыг онцгойлон анхаарч орчин үеийн техник хэрэгслээр хангаж, Монгол үндэстний аюулгүй байдлын төлөө дайчилна. Зах зээлийн эдийн засагтай ардчилсан жижиг үндэстэн болох Израйль, Швейцарийн шилдэг туршлагыг үндэслэн, үндэстний аюулгүй байдлыг дархлаажуулж, Монгол хүнийг эрүүл мэнд, эх оронч, сахилга баттай, хүмүүжилтэй, эрэлхэг, баатарлаг, нийтэч, ахан дүүсэг, эв нэгдэлтэй, шударга, шулнуун эрдэмтэй болгохын тулд Монгол хүн бүрийг 17-60 нас хүртэл жил болгон тодорхой хугацаанд цалинтайгаар цэргийн алба хаалгахыг хуульчилна. Дүйцүүлэх цэргийн албыг хүчингүй болгоно.

Монголд оршин суух гадаадын иргэдийн квотыг хязгаарлаж үндэсний дархлааг хадгалах бодлого барина. Хоол хүнсээр дамжуулан засаглал тогтоох, бодлогын эсрэг хүнсний ханган нийлүүлэлт, импортыг орлох бүтээгдэхүүн дэмжих бодлого явуулна.

Монгол хүний оюуны дархлааг устгах оюуны террорист үйл ажиллагааг явуулж буй аливаа хэлбэрт хяналтын тогтолцоог бий болгож, таслан зогсоож үйл ажиллагааг явуулна.

Газрын лиценз, аж ахуй эрхлэх нэрийдлээр Монголын газар шороонд эрээ цээргүй хандах хүмүүсийн үйл ажиллагааг таслан зогсоож, тусгаар тогтнолыг дархлаажуулна.

№ 803
18 он 04 сар 2012 одор

13. ГЕОПОЛИТИКИЙН БОДЛОГО

Монгол үндэстэн өөрийн амбицыг илэрхийлсэн газрын зургийг гаргаж түүн дээрээ бодлогоо явуулна. Эзэнт гүрний үеийн шиг газар нутгаар биш үндэстний хүчтэй бодлогоор газрын нутгаа тодорхойлно..,

Зорилт 1. Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ.

-Үе шат 1- (2016-2020): Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгох, Улаанбаатар хот болон бусад хот сууринг дахин төлөвлөх, барилгын дулааны алдагдлыг 20 хувиар бууруулах.

13.1 ДЭЛХИЙН ГОЕПОЛИТИКИЙН БОДЛОГО

Зөвшөөрөхгүй..,

Жалга довоор хуваагдаж, улам жижигрэх хүсэл, нам, нутаг улс гэж хуваагдах байдлыг...

Ингэж шийднэ. Дэлхийн хүчирхэг үндэстнүүд өөр өөрийн гэсэн гоеполитикийн газрын зургийг гаргаж түүнийгээ улс төр, эдийн засгийн хөгжлийн шинэ хандлагад ашиглаж байна. Тиймээс бид ч гэсэн байрлалын давуу талыг ашиглан өөрийн гэсэн улс төр, эдийн засгийн геополитикийн газрын зургийг гаргаж амбицаа илэрхийлнэ.

Америк төвийн эдийн засгийн хөгжлийн бүс (Хойд Америк, Латин Америк, Япон, Өмнөд Солонгос, Хойд Солонгос)-ийн зах зээлд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлэх зорилготой мэдлэгт суурилсан хотыг зүүн бүсэд байгуулах судалгаа хийж, техник эдийн засгийн үндэслэгээг боловсруулна. Зүүн бүсийн хөгжлийн хот нь Америк тивийн эдийн засгийн хөгжилтэй шууд уялдаж ажиллахаар төлөвлөнө.

Өмнөдийн эдийн засгийн хөгжлийн бүс (Хятад, Энэтхэг, Зүүн өмнөд Ази, Австрали, Шинэ Зеланд)-ийн зах зээлд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлэх зорилготой мэдлэгт суурилсан хотыг говийн бүсэд байгуулах судалгаа хийж, техник эдийн засгийн үндэслэгээг боловсруулна. Говийн бүсийн хөгжлийн хот нь Өмнөд зүгт хиллэх орнуудын эдийн засгийн хөгжилтэй шууд уялдаж ажиллахаар төлөвлөнө.

Баруун өмнөд бүс (Төв Ази, Баруун өмнөд Ази, Африк тив)-ийн зах зээлд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлэх зорилготой мэдлэг суурилсан хотыг баруун бүсэд байгуулах судалгаа хийж, техник эдийн засгийн үндэслэгээг боловсруулна. Баруун бүсийн хөгжлийн хот нь Баруун зүгт хиллэх орнуудын эдийн засгийн хөгжилтэй шууд уялдаж ажиллахаар төлөвлөнө.

Хойд бүс (Орос, Зүүн Европ, Баруун Европ)-ийн зах зээлд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлэх зорилготой мэдлэг суурилсан хотыг Хангайн бүсэд байгуулах судалгаа хийж, техник эдийн засгийн үндэслэгээг боловсруулна. Хангайн бүсийн хөгжлийн хот нь Орос, Европын эдийн засгийн хөгжилтэй шууд уялдаж ажиллахаар төлөвлөнө.

Эдгээр 4 бүсэд орших улс орнуудын зах зээлийн судалгааг гаргаж, тэр зах зээлд зориулсан дотоодын бүсчилсэн хөгжлийн бодлогыг дараах байдлаар хот болон зохион байгуулах судалгаа хийж, техник эдийн засгийн үндэслэгээг боловсруулна.

13.2 ДОТООДЫН ГАЗРЫН ЗУРАГ

Аймаг, сум гэх мэт Монгол хүнийг тарааж хэрэлдүүлж байлаах гэсэн атгааг бодлогоо бол Манжийн үеийн Монголын эсрэг бодлого юм.

13.3 МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХ СУУРЬ СУДАЛГАА ХИЙНЭ.

Зөвшөөрөхгүй...

Ард түмнийг түгжрэлд цагийг үрдэг, аливаа төрлийн хязгаарлалт тогтоож, хэт төвлөрөл явуулж тав тухтай амьдрах эрхийг хязгаарлаж, хаана ч амьдрах эрхийг үгүйсгэх хандлагыг..,

Ингэж шийднэ. Монголын түүхийн хамгийн том дурсамжтай, санамжтай газар нийслэлээ байгуулах суурь судалгааг хийж, техник эдийн засгийн үндэслэгээг боловсруулна. Дэлхийн зах зээлд чиглэсэн гол удирдлагын тодорхойлох төв хотыг төвийн бүсэд байгуулах суурь судалгааг хийж, техник эдийн засгийн үндэслэгээг боловсруулна.. Монгол Улсын нийслэлийг шинээр байгуулах газрыг сонгож 2018 ондоо багтааж УИХ-аар батлуулах ажлыг эхлүүлнэ. Тус нийслэл нь дэлхийн улс төрийн, эдийн засгийн, шинжлэх ухааны төв болгохоор төлөвлөнө.

13.4.БУСИЙН ХӨГЖЛИЙН ХОТУУДЫГ БАЙГУУЛАХ СУУРЬ СУДАЛГААГ ХИЙЖ ДУУСГАНА.

Монгол орныг хөгжлийн 5 бүсэд хуваан зохион байгуулна. Төвийн бусийн хот, Говийн бусийн хөгжлийн хот, Баруун бусийн хөгжлийн хот, Хангайн бусийн хөгжлийн хот, Зүүн бусийн хөгжлийн хот гэсэн 5 бүсэд хотуудыг байгуулах суурь судалгааг хийж, техник эдийн засгийн үндэслэгээг боловсруулна.

Говийн бусийн хөгжлийн хот нь Өмнөд зүгт хиллэх орнуудын эдийн засгийн хөгжилтэй шууд уялдаж, ажиллах харьяа зах зээлд тулгуурласан R&D төвтэй байхаар судална.

Баруун бусийн хөгжлийн хот нь Баруун зүгт хиллэх орнуудын эдийн засгийн хөгжилтэй шууд уялдаж, ажиллах харьяа зах зээлд тулгуурласан R&D төвтэй байхаар судална.

Хангайн бусийн хөгжлийн хот нь Орос, Европын эдийн засгийн хөгжилтэй шууд уялдаж, ажиллах харьяа зах зээлд тулгуурласан R&D төвтэй байхаар судална.

Зүүн бусийн хөгжлийн хот нь Америк тивийн эдийн засгийн хөгжилтэй шууд уялдаж ажиллан харьяа зах зээлд тулгуурласан R&D төвтэй байхаар судална.

Баруун, Зүүн, Хойд, Өмнөд болон Нийслэл гэсэн таван бүс тус бүрдээ ирж яваа шинжлэх ухаан, технологийн 6, 7 дахь хувьсгалыг угтсан стратегийн дагуу, түүнд тохирсон дэд бүтэц бүхий хамгийн орчин үеийн хотуудыг байхаар төлөвлөнө.

Бүсүүдэд сургууль, цэцэрлэг, их сургууль гээд цогцолбор хэлбэрээр байгуулахаар судалгаа хийгдэнэ.

13.5. ДАГУУЛ ХОТУУДЫГ БАЙГУУЛНА.

Зөвшөөрөхгүй...

Байгалийн баялагт тулгуурлан байгуулж дараа нь балгас болж үлдэх дагуул хотуудыг зөвшөөрөхгүй...

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН Г**

УХА0122

№ 803

Он 04 сар 2019

Ингэж шийднэ. Орхон хөндий мэт Монгол үндэстний түүхийн баархал болсон архитектурын хайгуулын үндэстний стратегийн салбар болгон тодорхойлж, архитектурын олдвор дээр нь музейнууд байгуулж, даяарчилсан аялал жуулчлалын дагуул хот, соёлын аж үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор философи, утга зохиол, жүжгийн зохиол, кино аж үйлдвэр болон нийгмийн дэд бүтцийг хосолсон дагуул хотуудыг бусийн хотуудад тулгуурлан байгуулж болох суурь судалгааг хийж УИХ-д өргөн мэдүүлнэ.

14. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Эрчим хүч гаргах боломжит эх үүсвэрүүдийг дэвшилтэт технологи тулгуурлан эрчим хүч экспорлогч орон болох холч бодлого хэрэгжүүлнэ. Эрчим хүчийг бие даан үйлдвэрлэхэд бодлогоо чиглүүлнэ.

Зөвшөөрөхгүй...

Ганц станц барина гэж уйдтал ярихыг, эрчим хүчний хүрэлцээ муу байгааг, нүүрс, уран, сэргээгдэх эрчим хүч гээд олон эх үүсвэрийг зориатой ашиглаж чадахгүй байгааг..,

Зорилт 1. Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулна.

-Үе шат 1-(2016-2020): Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, нүүрс, занарыг шингэрүүлэх, хийжүүлэх дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар хулэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон хэмжээнээс 2 хувиар бууруулах, байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог 2 дахин нэмэгдүүлэх.

Ингэж шийднэ. Эрчим хүчний эх үүсвэрийг шийдэхдээ Улаанбаатарт У цахилгаан станц байгуулах теслийг үргэлжлүүлнэ.

Нүүрсний ордуудад тулгуурлан өмнөд хил дагуу дулааны цахилгаан станцуудыг байгуулах суурь судалгааг гаргана. Говийн бусийн хотыг хангаж, урд хөрш рүү экспортлох бодлоготойгоор техник эдийн засгийн үндэслэлээг гаргана.

Нар, салхи, газ сэргээгдэх эрчим хүчний үүсвэрийг дэмжиж, иргэнээсээ илүүдэл эрчим хүчийг төр худалдан авдаг тогтолцоог бий болгохыг зорино.

14.1 ЭРЧИМ ХҮЧ, ТУЛШНИЙ САЛБАРЫН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Бодлого 1. Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системийг байгуулж, эрчим хүчний салбарын ашигт ажиллагааны түвшинг дээшлүүлэн, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого явуулна.

Ингэж шийднэ.

- Говийн бусийн цахилгаан хангамжийн бодлогыг тодорхойлж ойрын жилүүдэд бий болох Оюутолгой, Цагаансуварга болон бусад уул уурхайн үйлдвэрүүдийн эрчим хүчний хангамжийн эх үүсвэрийг бий болгох ажлыг бодлогоор дэмжих;
- Эрчим хүчний салбарт орчин үеийн тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулахад чиглэсэн бодлого явуулах.

Бодлого 2. Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн бодлого явуулна.

Ингэж шийднэ.

- Улаанбаатар хотын эрчим хүчний хангамжийг сайжруулах асуудлыг дэмжиж бага оврын 3-50 мегабатт-ын цахилгаан станцуудыг дүүрэг бүрт байгуулна.
- Бус нутгуудын эрчим хүчний системийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого явуулна.

Бодлого 3: Нүүрсний хийн бага оврын цахилгаан станцуудыг байгуулж, хөдөө орон нутгийн эрчим хүчний хангамжийг сайжруулахад чиглэсэн бодлого явуулна.

Ингэж шийднэ.

- ✚ Нүүрсний ордуудад ойрхон байрлалтай сүм, суурин газарт нүүрсний хийн түлшээр ажилладаг бага оврын цахилгаан станц барьж ажиллуулахад чиглэсэн бодлого явуулна.
- ✚ Нүүрснээс утаагүй түлш үйлдвэрлэдэг бага оврын үйлдвэрүүдийг байгуулахад чиглэсэн бодлого явуулна.
- ✚ Нүүрс боловсруулах, хийжүүлэх, шингэрүүлэх тоног төхөөрөмж бүхий нүүрс-химийн судалгааны лаборатори, төв байгуулж ажиллуулахыг санхүүгийн бодлогоор дэмжинэ.
- ✚ Нүүрснээс газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж, импортыг бууруулахад чиглэсэн санхүүгийн бодлогоор дэмжинэ.

15. “САХИЛГАТАЙ МОНГОЛ” ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Зөвшөөрөхгүй..,

- ✚ Одоогийн тархай бутархай засаг захиргааны нэгжийг холбох гэсэн ородлого, хэт жижиглэсэн бодлогогүй үйлдлүүдийг, дэлхийн зах зээлтэй холбогдохгүй байгааг, 60-70 км/цаг явдаг “яст мэлхий”-н хурдтай галт-тэргийг хэрэглэхийг..,

Ингэж шийднэ.

Зөвхөн газрын баялагийг зөөх гэсэн явцуу эрх ашигийн дэд бүтэц бол хэрэглэгдэхгүй үлдэнэ. Алсын хараатай хөгжлийн дэд бүтцийг байгуулах Монголын ирээдүйд хэрэгтэй..,

Дэд бүтцийг хүн ам, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, эдийн засгийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхийн зэрэгцээ эрчим хүч экспортлох, бус нутгийн сүлжээнд нэгтгэх, зам тээврийг Ази, Европыг холбосон гүүр, тээвэр зуучлалын үйлчилгээ болгон хөгжүүлэхэд бодлогоо чиглүүлнэ. Дэд бүтцийн салбарт хувийн хэвшлийн оролцоог дэмжинэ.

15.1 ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Бодлого 1. Авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлж, эхний ээлжинд бус, аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хүчилттай замаар холбоход чиглэсэн бодлого явуулна:

Ингэж шийднэ.

- ✚ Олон улсын авто замын сүлжээнд нэгдсэн чиглэлүүдийн дагуух авто замыг барихад чиглэсэн бодлого явуулна.
- ✚ Баруун болон зүүн, хойд болон өмнөд бусуудийг нийслэл хоттой төмөр замаар холбох суурь судалгааг хийнэ. Баруун болон зүүн, хойд болон өмнөд бусуудийг нийслэл хоттой төмөр замаар холбож, ачаа тээврийн коридоруудыг үүсгэх судалгааг хийнэ.
- ✚ Олон улсын төмөр замын тээврийн тээвэр ложистикийн төвийг байгуулж, транзит тээврийг хөгжүүлж, дэлхийн зах зээлтэй холбох ажлыг эхүүлнэ.

Бодлого 2. Авто замын салбарт дэвшилтэд техник технологийг нэвтрүүлж, авто зам, замын байгууламжийн ашиглалт, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн бодлого явуулна.

Ингэж шийднэ.

- Монгол орны байгаль цаг уурын нөхцөлд тохирсон авто зам барих технологи боловсруулан нэвтрүүлж, техник технологийн шинэчлэлийн хийхэд чиглэсэн санхүүгийн бодлого явуулах;
- Авто замын мэргэжилтэй ажилтан, ажилчид бэлтгэх, сургалтын төв байгуулж, хүний нөөцийг сайжруулахад чиглэсэн санхүүгийн бодлого явуулах.

Бодлого 2. Төмөр замын өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн бодлого явуулна.

УХА0122

№

80

20 . . . он . . . сар . . .

18

04

9

Ингэж шийднэ.

- Гол төмөр замын дагуу зэрэгцээ зам барих ажлыг бодлогоор дэмжих;
- Баруун бүсийг төмөр замын гарцтай болгох асуудлыг бодлогоор дэмжих;
- Төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээ байгуулах асуудлыг оновчтой төлөвлөх;
- Холбоо, мэдээллийн орчин үеийн цахим сүлжээнд суурилсан хөдөлгөөний удирдлага, хориглолын болон аюулгүй байдлын хяналтын системүүдийг нэвтрүүлэх.

Бодлого 3. Агаарын тээврийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, өрсөлдөх чадварыг нь сайжруулахад чиглэсэн бодлого явуулна.

Ингэж шийднэ.

- «Улаанбаатар хот орчимд олон улсын шинэ нисэх буудал байгуулж, орон нутгийн нисэх буудлуудыг агаарын хөлгийн хатуу хучилттай зурvas, гэрэл суултын системээр тоноглоход чиглэсэн бодлого явуулах.

Бодлого 4. Улаанбаатар хотын авто замын сүлжээ, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулахад чиглэсэн бодлого явуулна.

Ингэж шийднэ.

- Улаанбаатар хотын авто замыг хот төлөвлөлт, тээврийн бодлоготой уялдуулан сайжруулахад чиглэсэн санхүүгийн бодлого явуулах;
- Улаанбаатар хотын доторх нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулж, нийтийн зорчигч тээврийн компаниудыг хувьчлан, үнэ тарифыг чөлөөт тогтолцоонд шилжүүлж, паркийг шинэчлэх ажлыг бодлогоор дэмжих;
- Дотооддоо цахилгаан тээврийн хэрэгсэл угсарч үйлдвэрлэх, Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд тээврийн шинэ төрөл систем, авто замын хөдөлгөөнд удирдлага, зохицуулалтын тээврийн системийг нэвтрүүлэхийг бодлогоор дэмжих.

15.2 МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Бодлого 1. Мэдээлэл холбооны технологийн салбарын хөгжлийн санхүүгийн эрх зүй, эдийн засгийн нэн таатай орчин бүрдүүлнэ.

Ингэж шийднэ.

- Мэдээлэл холбооны өндөр хурдны мэдээллийн орчин үеийн дэд бүтэцтэй болоход чиглэсэн бодлого явуулах;
- Мэдээлэл, холбооны салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих;
- Сансрыйн холбооны хиймэл дагуулын сувагтай болох;
- Улсын болон хувийн салбарын түншлэлийг хөгжүүлэх.

15.3 ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Ингэж шийднэ.

- Улаанбаатар хотын инженерийн шугам сүлжээг дахин төлөвлөлт хийж, иргэний хувийн өмчийг хамгаалсан байдлаар зохион байгуулна.

Бүсийн 5 хотод инженерийн шугам сүлжээг шинээр төлөвлөн зохион байгуулах суурь судалгаа, инженерийн шугам сүлжээний дэд бүтцийн судалгааг хийнэ.

16. “САРУУЛ МОНГОЛ” ШИНЖЛЭХ УХААН, ИННОВАЦЫН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Мэдлэгэтийн тулгуурласан шинжлэх ухаанжсан хөгжлийг хангахауйгээр хөгжих бололцоогүй юм. Шинжлэх ухаанд хөрөнгө оруулалт хийгэхгээр дэлхийн эдийн засагт оролцож чадахауй..,

Зорилт. Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлнэ.

-Ye шат 1-(2016-2020). Инновацийг дэмжиж үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд шинжлэх ухааны байгууллага, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг ДНБ-ий 2 хувь хүртэлх түвшинд хүргэх.

Зарчим баримтална:

Мэдлэгийг баялаг болгох
Шинжлэх ухаанаас бодит бүтээгдэхүүн гаргах
Үндэсний эрх ашгийг түрүүнд тавих
Хувийн өмчид халдахгүй байх
Төрийн дэмжлэг үзүүлэх
Дэлхийн зах зээлээс мөнгө олох
Мэдлэгт суурилсан байх
Ухамсарт тулгуурласан байх

16.1. ШИНЖЛЭХ УХААН, ИННОВАЦЫН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Зөвшөөрөхгүй..,

Монгол үндэстний төлөө хуруугаа хөдөлгөх дургүй, шинжлэх ухааны академийн сэтгэлгүй үйл ажиллагааг, инновацийг хэрэгжүүлэх оролдлогогүй улс төрийн шийдлийг, шинжлэх ухаанд хөрөнгө оруулалт хийдэггүй гаж тогтолцоог..,

Ингэж шийднэ. Монгол үндэстний шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжилд Үндэсний хөрөнгө оруулалтын сангаас шууд санхүүжүүлж, шинэ менежмент нэвтрүүлнэ.

Үндэстний корпорациуд дээр тулгуурлан дэлхийд зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүн бүтээх ажлыг хурдацтайгаар хэрэгжүүлнэ.

Бүсийн хотуудад “MONGOLS VALUE-7” төслийг хэрэгжүүлж, мэдлэгийг баялаг болгоно. Үнийг хэрэгжүүлэхдээ Монгол гаралтай дэлхийн чиглэл чиглэлээр бэлтгэгдсэн хүмүүсийг ашиглана. Selicon Valley, Princeton advanced institute, Max-Planck Fraunhofer, Santa Fe Institute, Helmholtz Association, Leibniz Association, Alexander Van Humboldt Foundation эдгээр загвараар Монгол үндэстний стратегийн шинжлэх ухаан, стратегийн технологи, стратегийн инновацийн төвүүдийг бие даасан байдлаар байгуулна.

Шинжлэх ухаанд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг ҮДНБ-ний 2 хувьд хүргэнэ.

Үндэстний стратегийн технологи, стратегийн инновацийн нийт төсвийн хэмжээг ҮДНБ-ний 2 хувиас багагүй байлгана.

17. “САНХҮҮТЭЙ МОНГОЛ-(9+1)” ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХУВСГАЛ

Уриа: Нэгдүгээрт үйлдвэр, Үйлдвэр, үйлдвэр, үйлдвэр бас дахин үйлдвэр

2050 онд дэлхийн ДНБ 385 триллион ам.долларт хүрнэ. Ард түмэндээ ашиг хүртээх холч бодлого явуулна. Монгол улс хувийн өмч дээр тулгуурласан хамтаараа амьдрах тогтолцоог сонгох ёстой. Сайн намаймаачин нутаг руугаа юм оруулдаг, Муу намаймаачин нутгаа цөлмэдэг. Ш.Шеншоль

Зарчим баримтална

Үндэсний эрх ашгийг түрүүнд тавих
Хувийн өмчид халдахгүй байх
Нэгч Монгол хүн ашгийн гадна байхгүй байх
Төрийн дэмжлэг үзүүлэх
Дэлхийгээс мөнгө олох
Мэдлэгт суурилсан байх
Ухамсарт тулгуурласан байх

№ 802
20... он .04 сар

"Шинэ либерализмын идеологид автагдсанаас болж, дэлхийн хүчирхэг орон АНУ төрийн хяналтаа алдаж, 2009 онд санхүүгийн хямралд орж, АНУ-ын ардчиллын амин сүнс болсон дундаж давхаргаа устгасан" гэж Фрэнсис Фукуяама бичсэн.

Мэдлэгт суурилсан хамтын зах зээлийн эдийн засгийн тогтолцоог хэлбэршүүлэх замаар Монгол улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулалт орж ирэх бүхий л бололцоог бүрдүүлж, экспортын баримжаатай үйлдвэрүүдийг улс дамнасан үйлдвэрүүд болгож хөгжүүлж, оффшор бус болон гадаадын оронд мөнгө, хөрөнгөө байршуулсан эрх мэдэлтэнгүүдийн хөрөнгөө татуулах арга хэмжээг зохион байгуулах нь цөм зорилго тавин ажиллана. Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бутцийг төрөлжүүлнэ.

Эдийн засгийн бодлогын хувьсгалын Макро эдийн засгийн зорилгууд:

- ✚ Монгол Улсын Үндсэн хуульд заасанчлан өмчийн бүх хэлбэрийг хүндэтгэж, хувийн компанийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ. Нийгмийн хөгжлийн асуудлууд тулгамдаж буй нөхцөлд төрийн өмчит компани нь эрдэс баялаг, эрчим хүч, нийтийн тээвэр зэрэг салбарт чухал үүрэг гүйцэтгэдгийг санаж, түүнийг чадавхжуулахад онцгой анхаарна.
- ✚ Урт хугацааны эдийн засгийн дундаж өсөлтийг 7.8 хувиас доошгүй байлгана;
- ✚ Нэгдсэн төсвийн тэнцлийг алдагдалгүй байлгах, төсвийн тэнцлийн алдагдалын ДНБ-д эзлэх хувийг /уул уурхайн салбарын орлогыг тооцохгүйгээр/ 2020 онд 10 хувиас ихгүй байлгана.,
- ✚ Төсвийн тэнцлийн зохистой харьцааг чанд баримтлаж, ДНБ-д эзлэх төсвийн нийт зарлага /улсын нэгдсэн төсөв болон Хөгжлийн банкны санхүүжилтийг бүхэлд нь тооцсоноор/-ыг 2020 онд 30 хувь хүртэл бууруулна;
- ✚ Гадаад өр төлбөрийн асуудлыг үндэсний эрх ашгийг хамгаалах үүднээс оновчтой зохицуулна. Өрийн дээд хязгаарыг дотоодын нийт бүтээгдэхүүний 58.6 хувиас бага байлгах бодлого хэрэгжүүлнэ.
- ✚ Гадаад зах зээл дэх Монгол Улсын зээлжих зэрэглэлийг тогтмол дээшлүүлж ВВ болгоход чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ.
- ✚ Гадаад зах зээлийн болон түүхий эдийн үнэ ханшийн хэлбэлзлээс сэргийлэх бодлогыг баримталж, хуримтлалын санг бий болгон арвижуулах;
- ✚ Монгол улсын ашигт малтмал, байгальн баялагийн нөөц, гадаад валютын нөөц, тэтгэврийн сан, даатгалын сан, үндэстний төрийн өмчит корпорациудын орлогын эх үүсвэрээс Үндэстний Хөрөнгө Оруулалтын Санг байгуулна.
- ✚ Төлбөрийн тэнцлийг алдагдалгүй төлөвлөн хэрэгжүүлэх, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангаж, инфляцийг тогтвортой байлгаж 7 хувиас хэтрүүлэхгүй барина.
- ✚ Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, санаачлагад нэгдэж, эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулж, бус нутгийн шинжтэй томоохон төслүүдийг хэрэгжүүлнэ.
- ✚ Мал аж ахуй, газар тариаланг баялаг бүтээгч эдийн засгийн цөм, хүнсний аюулгүй байдлыг хангах стратегийн салбар, экологийн цэвэр бүтээгдэхүүний эх үүсвэр гэж үзэж, дотоодын хүнсний хэрэгцээг хангах хамгаалалттай бодлого

хэрэгжүүлэхийн зэрэгцээ улсын экспортын чухал хэсэг болгон хөгжүүлнэ.

ГАЗАР

17.1 ЭДИЙН ЗАСГИЙГ ЗАСАХ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛНЭ.

Консервативизмын эдийн засаг нь сонгодог либерал, шинэ либерал хамтын зах зээлийн эдийн засгийн хэлбэрүүдтэй байдаг. Сонгодог болон шинэ либериал эдийн засаг нь дураараа авирлагчдыг, хувшинаа бодогчдыг таруулсан улс орныг санхүү, эдийн засаг, нийгмийн хямралд хүргэдэг.

Дэлхийн түүхэнд гарсан хямралууд нь либериал эдийн засгийн бодлогыг баримталж, хэрэгжүүлснээс л үүдэлтэй байдаг. Тиймээс Монгол орон улс төрийн хувьд барууны консерватив, идеологитой байж, эдийн засгийн хувьд үндэстний ашиг сонирхлыг дэмжсэн, хүн бүрт ашиг нь хүрч чадах хамтын зах зээлийн эдийн засгтай байх учиртай.

Зөвшөөрөхгүй..

Монгол хүний эд хөрөнгийг үнэгүйдүүлж, Монгол хүний хөдөлмөрийг мөлждэг үйлдэл, хэдхэн хүний эрх ашгийн төлөө үйлчлэх олигархийн тогтолцоог, экологийн сүйрэл авчирч буй уул уурхайг цэлмэх бодлогыг..,

Ингэж засна.

Эдийн засгийг засах бодлогын зорилтууд.

- ✚ Макро эдийн засгийн хүрээнд мөнгөний бодлого, Монголбанкны хүүгийн бодлого, арилжааны банкны хүүгийн бодлогыг эрүүлжүүлж, хүүг бууруулах ажлыг зохион байгуулж, хэт өндөр хүүгээр дарамт үүсгэх нөхцөлийг арилгаж бодлогын хүүг 10 хувиас доош болгох зорилт тавин ажиллана.
- ✚ Инфляци, хэрэглээний үнийн индексийг бодитоор тооцон таргаж, үнэн мэдээллийг олон нийтэд хүргэж, хэрэглээгээр дамжуулан иргэдийг шулах бодлогыг таслан зогсоно.
- ✚ Иргэнийг орлого муутай, хэрэглээгээ гүйцэхгүй байгаа байдлыг арилгаж, иргэнийг эдийн засгийн чадавхитай байх нөхцөлийг хамтын зах зээлд тулгуурлан хэрэгжүүлж иргэд руу мөнгөний урсгал бий болгох тогтолцоог бүрдүүлнэ.
- ✚ Улс орны баялагаас олсон орлого, гадаад зах зээлээс олсон мөнгийг олигархиуд хүртдэг биш нийтээр ашиг хүртэх бололцоог бий болгоно.
- ✚ Экологийн сүйрэл авчирч буй шавхагдах баялаг болох уул уурхайн баялагийг үр дүнтэй дараагийн хөгжлийн хурдасгуур болгож хэрэглэнэ.
- ✚ Бэлчээрийн мал аж ахуйг таримал бэлчээрийн хэлбэрт шилжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, хуульчлан тогтоож өгнө.
- ✚ Өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл нийлүүлэлтийг төрийн эрх мэдэлд авч луйварчид ард түмний хөрөнгийг инфляциар дамжуулан луйвардахыг таслан зогсох ажлыг зохион байгуулна.

17.2. ЭДИЙН ЗАСГИЙГ ХҮЧИРХЭГЖҮҮЛЭХ БОДЛОГО ЯВУУЛНА.

Зөвшөөрөхгүй..

Чөлөөт эдийн засаг нэрээр улс эрх орны минь баялагийг зөөж буй санаатан, аливаа хэлбэрийн ашиг хүртээлтэнд шударга бус хандах хандлага, инфляци, татвар зэргээр бизнес эрхлэгчийг дарамтлах, хэрэглээний татвар нэрээр ард түмэнд үнийн дарамт үзүүлж буйг..,

Ингэж шийднэ.

- ✚ Макро түвшинд хамтын зах зээлийн эдийн засгийн бодлого, микро түвшинд зах зээлийн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлж эдийн засгийн өсөлтийг хангана.
- ✚ “ЭДИЙН ЗАСГИЙГ ЗОХИЦУУЛАХ БҮСЛҮҮР-78/22” төслийг хэрэгжүүлнэ.78 хувийн экспорлогч, 22 хувийн импортлогч орон

болно. Үүнд: Дотоодод үйлдвэрлэх боломжтой, үйлдвэрлэж буй бүх нэр төрлийн бүтээгдэхүүний гаалийн татварыг нэмэгдүүлж, хилээр орж ирэхийг хориглох хүртэл арга хэмжээ авна. Дотоодод үйлдвэрлэх боломжгүй бүх нэр төрлийн барааны гаалийн татварыг шат дараалалтай буруулах замаар хууль, журмыг боловсруулах батлуулахыг зорино.

- Монголд хамтын зах зээлийн эдийн засгийн тогтолцоог № 803
хэрэгжүүлнэ. Эдийн засгийг олон нийтийн компанийн баялаг бүтээдэг хэлбэрт шилжүүлж ажиллана. Яагаад? Төр эдийн засаг 2016 он 04 сар 22
хоёрын харилцааг хамгийн сайн хангадаг эдийн засгийн онол бол хамтын зах зээлийн эдийн засгийн онол юм. Хамтын зах зээлийн эдийн засагтай улс орнуудад үндэстний хэмжээний бүтээн байгуулалтууд өرنөж, үндэстний хэмжээний өрсөлдөхүйц корпорациуд бий болдог учраас ажилгүйдэл маш бага тувшинд байдаг. Мөн хөдөлмөрийн болон нийгмийн хамгааллыг өндөр хэмжээнд хангадаг. Эдийн засагт төрийн оролцоо (төрийн зохицуулалт гэдгийг зөвөөр ойлгох, төр ард түмнээ, иргэдээ хамгаалах үүрэгтэй) зохих хэмжээнд байдаг учраас инфляци, бодлогын хүү, үнийн хөөрөгдөл зэрэг нь үндэсний аюулгүй байдалд нелөөлнө гэж үзээд тодорхой стандартуудыг тогтоодог. Хамтын зах зээлийн эдийн засагт нэг аж ахуйн нэгж хоршооны талаар ярьдаггүй, харин үндэстний ажил эрхлэлт, үндэстний байгууллагууд, үндэстний асуудлуудыг ярьдаг. Хамтын зах зээлийн эдийн засаг чөлөөт зах зээлийн эдийн засагт буй хувийн өмч, чөлөөт өрсөлдөөн гэх зэрэг ойлголтуудыг дэмждэг ба ингэхдээ үндэстний хэмжээний асуудлуудыг, ард түмний эрх ашгийг эн тэргүүнд тавьдаг учраас..
- Өргөн хэрэглээний бараа (Max, сүү, гурил, будаа, хүнсний ногоо гэх мэт)-ны үнийг төрийн шууд зохицуулалтаар барьж, үнийг амьжиргааны бодит түвшинд ойр байхаар шийдвэрлэнэ. Инфляцийг дураар нь тавих биш төрийн зохицуулалттайгаар барьж чаддаг. Хамтын зах зээлийн эдийн засагт зээл гэдгийг ойлгоходо ард түмний сайн сайхны төлөө гэж ойлгодог. Тиймээс урт хугацааны, хүү багатай зээлийг санал болгодог.

Хамтын зах зээлийн эдийн засгийг хэрэгжүүлснээр: Эдийн засгийн өндөр өсөлт, амьдралд хүрэлцэхүйц хэмжээний цалин хөлс, ажилгүйдлийг бага түвшинд, импортлогч биш экспортлогч орон болно, амьдралын өндөр стандарт тогтооно.

- Олигархийн тогтолцоог бүрэн устгах зорилгоор төсвийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийг зөвхөн хувьцааных нь 80-аас багагүй хувийг хөрөнгийн биржээр арилжаалсан олон нийтийн хяналтан дор үйл ажиллагаагаа явуулдаг нийтийн өмчит аж ахуйн нэгжүүд дунд тендер зарлаж гүйцэтгүүлэх хуулийг санаачлан батлуулна.
- Глобалчлагдсан, мэдлэгжсэн, технологижсон эдийн засагтай болно. Хамтын зах зээлийн эдийн засаг нь өөрөө өндөр мэдлэг боловсрол, ёс суртахууныг шаарддаг. Тийм учраас эдийн засгийн бүхий л харилцаанууд мэдлэг боловсрол, ёс суртахуун дээр суурилдаг учраас хулхидана, залилан хийх гэх гэмт хэргүүд бараг гардаггүй ба эдийн засгийн үр ашгийг нийт үндэстэн, улс орноороо хүртдэг.
- Гадны биш дотоодын компаниудыг татвар болон эрх зүйн орчноор дэмждэг. Эдийн засгийн үр ашгийг нийт үндэстэн, улс орноороо хүртдэг учраас нийгэмд баталгаатай амьдралтай дундаж давхраа үүсдэг. Хамтын зах зээлийн эдийн засаг хувийн хэвшлийг ерөөсөө

үгүйсгэдэггүй харин ч улсаас дэмжиж хөнгөлттэй зээл, буцалтгүй тусlamжуудаар татаас олгодог.

- Монгол улсын шавхагдах баялагт тулгуурлан үл шавхагдах баялагийг бүтээж, Монгол хүн бүрт үр дүн, ашгийг тэгш хүртээх боломжийг бурдуулнэ. Хамтын зах зээлийн эдийн засгийн системд компани, корпораци, хувь хүмүүс нь хувьдаа ашиг олохыг чухалчилдаггүй ба нийт үндэстний эрх ашиг, үндэстний аюулгүй байдлын төлөө л ажилладаг.

17.3. ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН БАЙГУУЛНА.

Зөвшөөрөхгүй..,

Намын харьяат бизнес сэтгэлгээгүй хүмүүс төрийн сангуудын үйл ажиллагааг удирдахыг, татаасаар дээш гарсан мэдлэггүй хүмүүс хөрөнгө оруулалтын санг удирдахыг, хөрөнгө оруулалтын сангуудыг улс төртэй хутгалдаж байхыг...

Ингэж шийднэ. Монгол улсын ашигт малтмал, байгалин баялагийн нөөц, гадаад валютын нөөц, тэтгэврийн сан, даатгалын сан, үндэстний төрийн өмчит корпорациудын орлогын эх үүсвэрээс Үндэстний Хөрөнгө Оруулалтын Санг байгуулна.

Үндэстний Хөрөнгө Оруулалтын сан үндсэн гурван зорилготой.

Нэг дэх нь дотоодын үйлдвэр, компаниудаа дэмжиж дэлхийн тавцанд гаргах зорилготой.

Хоёр дахь нь дэлхийн тавцанд гарсан корпорациудаа дэмжих зорилготой.

Гурав дахь нь дэлхийн зах зээлд амжилттай явваа гадаадын корпорациудад хөрөнгө оруулалт хийх зорилготой.

Төрийн биш Үндэстний Корпорациудыг төрүүлнэ. Тухайн корпорациудын хувьцааг ард түмэнд эзэмшүүлж өгөөж хүртээнэ.

Үндэстний Хөрөнгө Оруулалтын Сан нь дэлхийн зах зээл буюу дэлхийн нийт баялагаас Монголын эзэмших хувийг нэмэгдүүлэхэд л чиглэх учиртай тул Монголын Корпорациудын эзлэх хувийг жинг дэлхийн зах зээл дээр нэмэгдүүлэхэд чиглэнэ.

17.4. ХУВИЙН БОЛ ОЛОН НИЙТИЙН ӨМЧИТ УЛС ДАМЖСАН ҮЙЛДВЭРҮҮД БАЙГУУЛАХЫГ ДЭМЖИНЭ.

Бизнес, улс төрийг ангид байлгах, засаглалын ил тод, шударга үйл ажиллагааг хангаж, эдийн засагт төрийн оролцоог эрс багасгах замаар авлигаас ангид орчин бурдуулнэ.

Үе шат 1- (2016-2020): хувийн өмчийн халдашгүй байдлыг баталгаажуулах, эдийн засаг дахь төрийн оролцоог багасгаж, бизнесийг улс төрөөс ангид байлгаж, бизнесийг өөрийн зарчмаар хөгжих хууль эрх зүйн орчинг бурдуулэх.

Зөвшөөрөхгүй..,

Жижиг дунд бизнесийг босохоос өмнө унагадаг гаж тогтолцоог, зах зээлдээ тохирсон жижиг бизнес эрхлэхийг уриалсан дэлхийн хараагүй бодлогыг..,

Ингэж шийднэ.

Зорилтууд.

- Хувийн хэвшлийг дэлхийн зах зээлд гарах дэмжлэг, менежментийг хэрэгжүүлж Монгол хүний оюун болон баялагт тулгуурласан бизнесийг дэмжинэ.
- Дэлхийн томоохон корпорациудад хөрөнгө оруулах аргаар дэлхийн эдийн засгаас ашиг хүртэж, иргэн бүрт хуваарилана. Монголоос дэлхийн хэмжээний томоохон корпорациудад хөрөнгө оруулна. Standard and Poor's-ийн шилдэг 500 дотор орсон корпорациудыг худалдаж авах, хөрөнгө оруулах замаар томоохон

корпорациудыг бий болгоно. Ингэж богино хугацааны дотор хөгжилд хүрэх боломжийг нээнэ.

Монгол хүний мэдлэгт тулгуурлан үндэстэн дамнасан корпорациудыг байгуулан дэлхийн зах зээлд өрсөлдөх нөхцөлийг хангана. "MONGOLS CAPITAL-78/22"- ийн судалгаанд тулгуурлан "MADE IN MONGOLS-78/22" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. 10.000 ажилчнитай үйлдвэрүүдийг байгуулахад бодлогоо чигүүлнэ. Иргэд хувьцааг нь эзэмшиж ашиг хүртэхээр хамтын зохион байгуулалтын № 803 хэлбэрт шилжүүлэхийг хуулчилна.

Зорилт 1. Аж үйлдвэрийг дэвшилтэт техники, технологи, инновацийг суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх.

-Үе шат 1- (2016-2020): Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх.

Зорилт 3. Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана.

-Үе шат 1- (2016-2020): Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээний 20 хувийг Евро 4 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах, зэс хайлуулах, алт цэвэршүүлэх, улмаар газрын тос, байгалийн хий, занар, нуурс боловсруулах, химийн бүтээгдэхүүн болон бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх.

Зорилт 1. Геологийн салбарын хөгжлийг дэмжинэ.

-Үе шат 1- (2016-2020): Геологи, геохими, геофизикийн бүх төрлийн судалгааны ажлыг иж бүрнээр гүйцэтгэх чадавхийг бэхжүүлж, судалгааны ажлын арга, аргачлал, зааврыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн заавар, аргачлалтай уялдуулан шинэчлэн боловсруулах, Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн 1:200000 масштабын зураглалд бүрэн хамруулан, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 40 хувьд гүйцэтгэх.

Зорилт 2. Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

-Үе шат 1 – (2016-2020): Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангаж, байгаль орчинд эзлтэй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлж, Говийн бүсийн томоохон хүчин чадал бүхий цахилгаан станц байгуулах.

Үүнд: Эдийн засгийн хөдөлгүүр хүч болсон 9 үйлдвэрийг байгуулна.

- Хөдөө аж ахуйн түшиглэсэн үйлдвэрүүд
- Аж үйлдвэр
 - Хөнгөн хүнсний үйлдвэрүүд
 - Барилгын материалын үйлдвэр
 - Зэс боловсруулах үйлдвэр
 - Хар төмөрлөгийн үйлдвэр
- Үндэсний уламжлалт үйлдвэрүүд
- Ургамал суурилсан био технологийн үйлдвэрүүд
- Уул уурхайн олборлох үйлдвэр

- Аялал жуулчлал зэрэг салбаруудад хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч ажиллана.
- Монгол залуу хүнийг Монгол хүнд эдийн засгийн өгөөж авчрах дотоодын болон үндэстэн дамнасан үйлдвэр байгуулах, бизнес эрхлэхийг төрөөс санхүүжүүлж, татварын бодлого, зээлийн хүүгийн бодлого, хамтын мененжментийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- Дэлхийн зах зээлийг судлах "MONGOLS CAPITAL-78/22" хөтөлбөрийг боловсруулж териин бодлого болгохыг зорино.
- Америк төвийн эдийн засгийг судлах 2200 залуусын "AER-78/22" багийг ажиллуулна. Үүнд: Хойд Америк, Латин Америк, Япон, Өмнөд Солонгос, Хойд Солонгосын зах зээл багтана.
- Өмнөдийн эдийн засгийг судлах 2200 залуусын "SER-78/22" багийг ажиллуулна. Үүнд: Хятад, Энэтхэг, Зүүн өмнөд Ази, Австрали, Шинэ Зеландын зах зээл багтана.
- Баруун өмнөдийн эдийн засгийг судлах 2200 залуусын "RSER-78/22" багийг ажиллуулна. Үүнд: Төв Ази, Баруун өмнөд Ази, Африк тивийн зах зээл багтана.
- Умардын эдийн засгийг судлах 2200 залуусын "NER-78/22" багийг ажиллуулна. Үүнд: Орос, Зүүн Европ, Баруун Европ тивийн зах зээл багтана..
- Монгол улсад үндэстний хэмжээний томоохон корпорациудыг байгуулан түүнийгээ дэлхийн зах зээлтэй холбоод дэмжлэг үзүүлэх хөрөнгө оруулалтын сан, дэлхийн зах зээл дээр Монголын корпорациудын эзлэх хувийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын сан байгуулна.
- Улс дамнасан үйл ажиллагаа явуулдаг судалгаа, үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээ бүхий Монгол үндэстний нийтийн өмчтэй үндэстний корпорациудыг байгуулна. "R and D" үндэстний корпорациудыг судалгаа хөгжлийн байгууллагууд, борлуулалт маркетингийн сүлжээ, мэдлэгт тулгуурласан үйлдвэрүүдээ байгуулах суурь судалгааг гаргаж, тусгайлсан үндэсний хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ.

17.5. СЭРГЭН МАНДАЛТЫН ТУСГАЙ ДАНС НЭЭЖ АЖИЛЛУУЛНА.

Уриа: Аеилгаас салах хувьсаал хийнэ.

Гүрж улсын адил авилгад алдсан ард түмний эд хөрөнгийг яаралтай олж авахын тулд орлогын эх үүсвэрээ шударга хөдөлмөрөөр олж авч чадаагүй хүмүүсийн эд хөрөнгийг Монгол улсын сэргэн мандалтын тусгай данс нээж яаралтай төвлөрүүлэх хуулиудыг батлуулж хэрэгжүүлнэ.

Зөвшөөрөхгүй...

Ард түмний бүтээн байгуулалтыг хувьчлал нэрээр авч луйвардсан үйлдэл, лиценз нэрээр газрын баялагийг хувийн эрх ашгийн төлөө ашиглагч нарын үйлдэл, шударга бусаар баяжигч нарыг, татварын мөнгөөр хөлжигседийн үйлдлийг, албан тушаалаа ашиглан авилгач нарын үйлдлийг ...

Ингэж шийднэ.

Зорилтууд.

- Ард түмний өмч, бүтээн байгуулалтыг өмч хувьчлал нэрээр хувьдаа завшсан нөхдийн үйлдлийг илрүүлж тэдний ард түмнийг хохироосон хохирлыг тогтоож, сэргэн мандалтын тусгай дансанд татан төлөвлөрүүлнэ.

- Газрын хэвлэлийн баялагийг хувийн эрх ашгийн зорилгоор ашиглан ард түмэнд өгөөжүйгээр хувьдаа завшигч нарын жагсаалтыг гаргаж, нөхөн төлбөр хэлбэрээр төвлөрүүлж, сэргэн мандалтын тусгай дансанд байрлуулна.
- Авилаа авч баяжсан нөхдийг хуулийн хүрээнд илрүүлж, тэдний авилгаар авсан мөнгийг сэргэн мандалтын тусгай дансанд татан төвлөрүүлнэ.
- Татварын мөнгөөр тендер, худалдан авалт, шахаа хийх замаар шамшигдуулсан мөнгийг эргүүлэн татаж, сэргэн мандалтын тусгай дансанд төвлөрүүлнэ.
- Олон улсад данстай, бизнестэй нөхдийг Олон улсын эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж хууль бус мөнгийг сэргэн мандалтын тусгай дансанд татан төвлөрүүлнэ.
- Улс дамнасан мөнгө угаасан гэмт хэргийн чанартай үйлдэл хийсэн нөхдийн мөнгийг илрүүлж, сэргэн мандалтын тусгай дансанд татан төвлөрүүлнэ.
- Тусгай санг нийгмийн эмзэг бүлэг болон ядуу бүлэгт зориулсан нийгмийн үйл хэрэгт зарцуулна. Нийгмийн туслын тулд зарцуулах тусгай санг дээрхи хэлбэрээр бүрдүүлэхийн тулд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

17.7. ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ САЛБАРУУДЫН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Эдийн засаийн бодит салбаруудыг санхүүгийн бодлогоор дэмжих замаар түргэн хурдацтай хөөжүүлнэ. Өндөр технологид тулгуурлан стратегийн орд газруудыг ашиглаж, эдийн засаийн бодит салбаруудыг хөөжүүлэх санхүүгийн хуримтлалыг бүрдүүлнэ.

17.7.1. БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Бодлого 1. Боловсруулах аж үйлдвэрийн салбарт өндөр технологийг нэвтрүүлж, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг санхүүгийн бодлогоор дэмжинэ.

Ингэж шийднэ.

- Өндөр технологийг тууштай нэвтрүүлж, дэлхийн зах зээлийн эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг боловсруулах аж үйлдвэрийн салбаруудыг хөгжүүлэхэд чиглэсэн санхүүгийн бодлого явуулах;
- Экспортын баримжаатай, оюуны багтаамжтай, өрсөлдөх чадвартай, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг санхүүгийн бодлогоор дэмжих;
- Оёмол, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг нь санхүүгийн бодлогоор дэмжих;
- Бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартад нийцүүлэн тасралтгүй сайжруулах.

Бодлого 2. Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг нь дээшлүүлнэ.

Ингэж шийднэ.

- Ноос, ноолуур, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэсэн санхүүгийн бодлого явуулах;
- Үйлдвэрлэлийн техник, технологийг сайжруулах, бүтээгдэхүүний загварыг шинэчлэх замаар дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх чиглэсэн санхүүгийн бодлого явуулах.

17.7.2. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Бодлого 1. Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих санхүүгийн эрх зүйн таатай орчинг бурдуулнэ.

Ингэж шийднэ.

- ✚ Экспортын баримжаатай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг гаалийн болон нэмэгдсэн өргтийн татварын бодлогоор дэмжих хуулийг анхлан санаачилаж УИХ-д өргөн барина;
- ✚ Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд үзүүлдэг ~~терийн~~ үйлчилгээг оновчтой болгох;
- ✚ Улсын болон орон нутгийн төсвийн захиалгаар бараа, үйлчилгээ худалдан авахад жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг тулхүү оролцуулах;
- ✚ Тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгогдож байгаа лиценз, зөвшөөрлийг On-line үйлчилгээнд бүрэн шилжүүлэх.

17.7.3. ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ХӨНГӨН ХҮНСНИЙ САЛБАРЫН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Бодлого 1. Мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ.

Ингэж шийднэ.

- ✚ Малын чанар, үргжийн ажлыг сайжруулж эрчимжсэн мал аж ахуйг бүсчлэн хөгжүүлэхэд чиглэсэн санхүүгийн бодлого явуулах;
- ✚ Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалахад чиглэсэн санхүүгийн арга, хэрэгслүүдийг ашиглах.

Бодлого 2. Газар ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариаланг хөгжүүлэн, газар

тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг санхүүгийн бодлогоор дэмжинэ.

Ингэж шийднэ.

- ✚ Усалгаатай газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийг урт хугацааны бага хүйтэй зээл (лизинг)-ээр олгож байгаа хөтөлбөрийг үргэлжүүлнэ.
- ✚ Төмс, хүнсний ногоо, жимсгэний үйлдвэрлэлийг санхүүгийн бодлогоор дэмжих;
- ✚ Өрхийн аж ахуйн гар ажиллагааг хөнгөвчлөх орчин үеийн бага оврын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг импортлодог болон дотооддоо үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжийг санхүүгийн бодлогоор дэмжих.

Бодлого 2. Хүнсний үйлдвэрлэлд өндөр технологийг нэвтрүүлж бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн санхүүгийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Ингэж шийднэ.

- ✚ Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг болон импортыг орлох хүнсний зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг санхүүгийн бодлогоор дэмжих;
- ✚ Тохиромжтой бус нутгуудад бөөний худалдааны төв, бирж байгуулж хүнсний бүтээгдэхүүний борлуулалтын оновчтой сүлжээг бий болгоход чиглэсэн санхүүгийн бодлого хэрэгжүүлэх.

17.7.4. УЛСЫН ТӨСВИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Судалгаанд суурилсан хөгжлийн бодлого нь макро здийн засаг, санхүүгийн нэн таатай орчин бурдуулэх, улсын төсвийн төлөвлөлтийг оновчтой болгох, татварын бодлогоор экспортын чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээт дэмжих, төлбөрийн балансын тэнцвэртэй байдлыг хангах, өрийг оновчтой удирдах, инфляцийг тогтвортой нам түвшинд барих, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн бүтээгдэхүүн(унэт цаас, даатгал, зээл, хадгаламж)-ийг иргэн бүрт

хүргэх санхүүгийн тогтолцоог хөгжүүлж, санхүүгийн салбарт эрсдэлийн хэрэгжүүлнэ.

Зорилтууд:

Зорилт 1. Улсын төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөж, үр ашигтай, хэмнэлттэй, оновчтой удирдан зарцуулна.

-Үе шат 1- (2016-2020): Улсын төсвийн алдагдлыг ДНБ-ий 2 хувиас ихгүй байхаар төлөвлөх.

Зорилт 2. Эдийн засгийн тогтвортой ёсөлтийг дэмжих хөгжлийн санхүүжилтийн болон санхүүгийн зах зээлийн зохистой тогтолцоог хөгжүүлнэ. Санхүүгийн зах зээлд банкны бус санхүүгийн байгууллагын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж, арилжааны банк, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийн эзлэх хувийг зохистой түвшинд хүргэнэ.

-Үе шат 1 - (2016-2020): Санхүүгийн зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгож, санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг 10 хувьд хүргэн нэмэгдүүлэх, арилжааны банкны эзлэх хувийг 90 хувьд хүргэн бууруулах, даатгалын зах зээлийн эзлэх хувийг ёсгөх.

Зорилт 3. Хөгжлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, гадаад, дотоод өрийн удирдлагын зохистой тогтолцоог бий болгон төлөвшүүлнэ.

-Үе шат 1 - (2016-2020): Хөгжлийн санхүүжилтийн зохистой тогтолцоог бий болгоно. Тулгамдаж байгаа гадаад өрийн асуудлыг эдийн засаг, төлбөрийн тэнцэлд дарамт учруулахгүйгээр бүтцийг өөрчлөн зохицуулж, гадаад өрийн ДНБ-д эзлэх хувийг 58,6 хувиас хэтрүүлэхгүй байж, өрийн зохистой түвшинг хангах.

Бодлого 1. Судалгаанд суурилсан хөгжлийн стратеги бодлого, Засгийн газрын санхүүгийн дунд болон урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүгийн төлөвлөлтийг чиглүүлнэ.

Ингэж шийднэ.

- ✚ Үндсэн чиглэл, төсөв, мөнгөний бодлогын уялдаа холбоог өнөөгийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх;
- ✚ Улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийн уялдаа холбоог хангах;
- ✚ Орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн эрх хэмжээг нэмэгдүүлж, хариуцлагын тогтолцоог сайжруулах;
- ✚ Төсвийн байгууллагуудын төсвийг бодит хэрэгцээнд нь нийцүүлэн төлөвлөж санхүүжүүлэх;
- ✚ Санхүүгийн дунд болон урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийг оновчтой болгох;
- ✚ Санхүүгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх.

Бодлого 2. Төсвийн хөрөнгө оруулалтыг судалгаанд суурилсан хөгжлийн стратеги бодлоготой уялдуулан тогтвортой нэмэгдүүлнэ.

Ингэж шийднэ.

- ✚ Судалгаанд суурилсан хөгжлийн бодлогын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд төсвийн бодлогыг чиглүүлэх;
- ✚ Төслүүдэд тулгуурлан улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх;
- ✚ Төсвийн хөрөнгө оруулалтыг хүнд өгөөжтэй эдийн засгийн ёсөлтийг дэмжиж, эдийн засгийн оновчтой бүтцийг бүрдүүлэхэд чиглүүлэх;
- ✚ Бүсүүдийн хөгжлийг хурдасгах төслүүдийг орон нутгийн засаг захиргаатай хамтран хэрэгжүүлэхийг бодлого барина.
- ✚ Эдийн засгийн чөлөөт бүс, үйлдвэрлэл технологийн паркууд байгуулахад шаардлагатай дэд бүтцийг барьж байгуулахыг бодлогоор дэмжих.

УХА0122

№ 203

Он 04 сар 2022

Бодлого 3. Хүн амын орлого багатай хэсэгт хандсан төсвийн зарлагын бодлогыг хэрэгжүүлнэ.³⁴⁹

Ингэж шийднэ.

- ✚ Хүний хөгжлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- ✚ Тэтгэвэр, тэтгэмжийг үндэсний орлогын өсөлттэй оновчтой уялдуулан нэмэгдүүлэх;
- ✚ Гадаадад өндөр мэргэшсэн мэргэжилтнүүдийг ~~бэлтгэхэд~~ төсвийн бодлогоор дэмжих.

Бодлого 4. Стратегийн орд газруудыг “Үндэсний хөрөнгө оруулалтын сан” бүрдүүлэх замаар зохистой ашиглана.

Ингэж шийднэ. Үндэсний хөрөнгө оруулалтын санг бүрдүүлж нийгэм эдийн засгийн хөгжлийг хурдасгах, макро эдийн засгийн тогтвожилтыг хангахад ашиглах.

17.7.5. ТАТВАРЫН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Татварын суурийг өөрчилж бага хувьтай, ялгаатай татварын тогтолцоог хэрэгжүүлнэ.

Бодлого 1. Экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээ, импортыг орлох үйлдвэрлэлийг татварын бодлогоор дэмжинэ.

Ингэж шийднэ.

- ✚ Эрдэс түүхий эд, ноос, ноолуур, мах, сүү, арьс шир боловсруулах салбарын үйлдвэрлэлд өндөр технологи нэвтрүүлэхийг татварын бодлогоор дэмжихийг хуульчилж мөрдүүлнэ.
- ✚ Нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг татварын бодлогоор дэмжийг хуульчлан мөрдүүлнэ.
- ✚ Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих татварын бодлогоор дэмжих ажлыг үргэлжлүүлнэ.
- ✚ Экспортын баримжаатай “Бренд” бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг татварын бодлогоор дэмжихэд онцгойлон анхаарч хуулична.
- ✚ Гаалийн тарифын бодлогыг үйлдвэрлэл, хэрэглээний зохистой харьцааг бий болгох, боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортыг дэмжихэд чиглүүлэх.

Бодлого 2. Татварын бааз суурийг өргөтгэн, татвар хураалтыг сайжруулах замаар татварын тогтолцоог шинэчилнэ.

Ингэж шийднэ.

- ✚ Татварын бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлэх;
- ✚ Татварын ачааллыг зохистой нам түвшинд барих;
- ✚ Хуримтлагдсан болон зээлийн татварын бодлогыг хэрэгжүүлэх;
- ✚ Татварын бааз суурийг жил бүрийн инфляцтai уялдуулан шинэчлэх;
- ✚ Цахим татварын системийг бүрэн нэвтрүүлэх;
- ✚ Татварын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх.

Бодлого 3. Бүс нутгийн хөгжлийг татварын бодлогоор дэмжинэ.

Ингэж шийднэ.

- ✚ Бүс нутгуудын жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг татварын бодлогоор дэмжих;
- ✚ Бүсийн тулгуур төвүүдийн хөгжлийг татварын бодлогоор дэмжих;

- Улсын хил орчмын бүс нутгийн хөгжлийг татварын бодлогоор **МОНГОЛ УЛСЫН
ИНДЭСНИЙ АУДИТЫН**

17.7.6. МӨНГӨ, ЗЭЭЛИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Бодлого 1. Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн, инфляцийг тогтвортой нам түвшинд барьж, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангана.

Ингэж шийднэ.

- Инфляцийн түвшинг бага түвшинд байлгаж, эдийн засаг дахь инфляцийн дарамтыг баг түвшинд барина;
- Дунд хугацаанд мөнгөний төлөвлөлтийг оновчтой болгох;
- Эрэлтийн болон нийлүүлэлтийн инфляциас хамгаалах оновчтой бодлогыг хэрэгжүүлэх;
- Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх;
- Гадаад валютын цэвэр албан нөөцийг эдийн засгийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх;
- Хадгаламжийн даатгалын хууль, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх.

Бодлого 2. Санхүү – банкны тогтолцоо, үйлчилгээг боловсронгуй болгоно.

Ингэж шийднэ.

- Санхүү – банкны тогтолцоог өндөр хөгжсөн орнуудын нийтлэг жишигт нийцүүлэн боловсронгуй болгох;
- Хөрөнгийн зах зээлийг сонгомол утгаар нь хөгжүүлэх;
- Өрсөлдөх чадвар бүхий үнэт цаасыг гадаад зах зээлд гаргаж, хөрөнгийн гадаад эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
- Засгийн газрын үнэт цаасны арилжааг хөрөнгө оруулалтын чиглэлээр өргөтгөх;
- Улаанбаатар хотыг Азийн бүс нутгийн санхүүгийн томоохон төв болгох.

Бодлого 3. Зээлийн хүүгийн бодлогод өөрчлөлт оруулж хөрөнгө оруулалт, бизнесийн нэн таатай орчин бүрдүүлнэ.

Ингэж шийднэ.

- Зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан зээлийн хүүг тогтоох;
- Зээлийн хүүгийн бодлогыг банкны эрсдэлийг багасгах бодлоготой нягт уялдуулан хэрэгжүүлэх;

17.7.7. ӨРИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Бодлого 1. Гадаад зээлийн хэмжээг зохистой түвшинд байлгаж, өрийн эрсдэлийг бууруулна.

Ингэж шийднэ.

- Засгийн газрын дунд болон хугацааны гадаад зээлийн хэрэгцээг оновчтой тогтоох;
- ДНБ-д эзлэх гадаад зээлийн хэмжээг зохистой түвшинд барих;
- Олон улсын санхүүгийн байгууллагууд, донор орнуудаас эдийн засаг, санхүүгийн хувьд өндөр үр ашигтай зээл авах чиглэлийг баримтлах;
- Дотоодын санхүүгийн зах зээлийг хөгжүүлж, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх замаар гадаадын зээл, тусlamжаас хамаарах хамаарлыг багасгах;
- Гадаадын буцалтгүй тусlamжийг нийгмийн салбарт чиглүүлэх.

Бодлого 2. Өрийн удирдлагыг оновчтой болгоно.

Ингэж шийднэ.

- Тухайн жилд авч болох зээлийн дээд хязгаарыг Засгийн газар тооцож, УИХ баталдаг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Гадаад зээлийн үр дүнг нь тооцдог бүртгэл, хяналтын механизмыг бий болгох;
- Эдийн засгийн ёсөлт тогтвортойлтуудыг дэмжсэн сангийн бодлоготой оршинон бодлогыг оновчтой уялдуулах.

ГАЗАР

17.7.8. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ САЙЖРУУЛАХ БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Бодлого 1..Хүнээ хөгжүүлж, мэдлэг чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн санхүүгийн оновчтой бодлого явуулна.

Ингэж шийднэ.

- Гадаадын оюунжсан өндөр технологид нэвтрэх боломжийг санхүүгийн бодлогоор дэмжих;

Бодлого 2. Үйлдвэрлэл, үйлчилгээнд өндөр технологийг нэвтрүүлж өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого явуулна.

Ингэж шийднэ.

- Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах санхүүгийн хууль, эрх зүйн таатай орчин бурдүүлэх;
- Эдийн засгийн чөлөөт бүсүүдийг хөгжүүлж өндөр технологи нутагшуулахад чиглэсэн санхүүгийн бодлого явуулах.

17.7.9. ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Бодлого 1. Гадаад худалдааны нэн таатай орчин бурдүүлэхэд чиглэсэн бодлого явуулна.

Ингэж шийднэ.

- Гадаад худалдааны санхүүгийн хууль эрх зүйн орчин бурдүүлэх;
- Дэлхийн худалдааны байгууллагын гишүүний хувьд худалдааны тааламжтай нөхцөлийг үр дүнтэй ашиглах;
- Экспортын хөнгөлөлт, тусгай нөхцөлийг бүрэн ашиглах;
- Дэлхийн болон бус нутгийн худалдааны интеграцид идэвхтэй оролцож, байр сууриа бэхжүүлэхэд чиглэсэн санхүүгийн бодлого явуулах;
- Бус нутгийн эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны байгууллагуудын хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж экспортын бүтээгдэхүүнийг санхүүгийн бодлогоор дэмжих.



Бодлого 2. Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх чиглэсэн бодлого явуулна.

Ингэж шийднэ.

- Эрдэс түүхий эдийн эцсийн бэлэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санхүүгийн оновчтой бодлого явуулах;
- Арьс шир, ноос, ноолуур зэрэг мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшинг дээшлүүлж, эрүүл ахуйн болон дэлхийн стандартын шаардлага хангасан экологийн цэвэр эцсийн бүтээгдэхүүний экспортыг санхүүгийн бодлогоор дэмжих.

Бодлого 3. Импортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг эдийн засгийн хөгжлийн хэтийн чиг хандлагатай оновчтой уялдуулан сайжруулахад чиглэсэн бодлого явуулна.

Ингэж шийднэ.

- Импортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг оновчтой болгох санхүүгийн бодлогыг чиглүүлэх;
- Өндөр технологи бүхий боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээ болон техник, тоног төхөөрөмжийн импортыг санхүүгийн бодлогоор дэмжих.

МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТЫ
УХА0122

17.7.10. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Бодлого 1. Жуулчин тээвэрлэлтийн болон жуулчин хүлээн авах байрны хүчин чадлыг нэмэгдүүлж, аялал жуулчлалын гол бус нутгийн зам харилцаа холбоо, эрчим хүчиний хангамжийг сайжруулахад чиглэсэн бодлого явуулна.

№ 803

18.04.2022

Ингэж шийднэ.

- Аялал жуулчлалын гол бус нутгуудын харилцаа холбоо, эрчим хүчиний хангамжийг сайжруулах ажлыг бусад салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого явуулах;
- Дээд зэрэглэлийн зочид буудал байгуулах зэрэг аялал жуулчлалын салбарт оруулах хувийн хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжих.

Бодлого 2. Аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг барьж байгуулан аялагч, жуулчдын сонирхлыг татсан аяллын төрлүүдийг бус нутгуудаар төрөлжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн бодлого явуулна.

Ингэж шийднэ.

- Улаанбаатар хот, Хөвсгөл нуурын орчим өвлийн спортын цогцолбор, Хужирт, Шаргалжуут, Цэнхэрийн халуун рашааныг түшиглэсэн жилийн турш жуулчин хүлээн авах бололцоотой амралт, сувиллын цогцолборуудыг байгуулж ажиллуулахад чиглэсэн бодлого явуулах;
- Аялал жуулчлалын мэргэжил сургалтын төвүүдийг Улаанбаатар хот, бусийн төвүүдэд байгуулахыг санхүүгийн бодлогоор дэмжих;
- Аялал жуулчлалын салбарын бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Аялал жуулчлалын үндэсний төвийг байгуулж ажиллуулах.

17.7.11. ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГЫН САЛБАРЫН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Бодлого 1. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоо бүрдүүлж, хот байгуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн санхүүгийн бодлого явуулна.

Ингэж шийднэ.

- Хот байгуулалтын санхүүгийн эрх зүйн орчинг сайжруулж, хот төлөвлөлтийн норм нормативийг боловсронгуй болгох;
- Бүсчилсэн хөгжлийн бодлогыг хот байгуулалтын бодлогоор дэмжих, Монгол улсын бус нутгуудын түвшинд хот суурин газруудын ангилал зэрэглэлийг тогтоож хот, тосгоны төлөвлөлтийг боловсронгуй болгоход чиглэсэн санхүүгийн бодлого явуулах;
- Нийслэл хотын хүн амын хэт бөөгнөрлийг задлаж, бусийн тулгуур төвүүд, орон нутгийн хотуудад зохистой төвлөрлийг бий болгоход чиглэсэн санхүүгийн бодлого явуулах.

Бодлого 2. Орчин үеийн чанарын шаардлагыг хангасан барилга, барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуйн салбарыг бий болгон хөгжүүлэхэд чиглэсэн санхүүгийн бодлого явуулна.

Ингэж шийднэ.

- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн норм норматив, стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох;
- Орон нутгийн түүхий эдийн нөөцд түшиглэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг санхүүгийн бодлогоор дэмжих;

Бодлого 3. Хүн амын орон сууцны хангамжийг эрс сайжруулахад чиглэсэн санхүүгийн бодлого явуулна.

Ингэж шийднэ.

- ✚ Орон сууц барих санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, орон сууцны урт хугацаатай зээлийн анхдагч ба хоёрдогч зах зээлийн тогтолцог хөгжүүлэх;
- ✚ Орон сууц барих санг байгуулж ажиллуулах;
- ✚ Хүн амын худалдан авах чадварт тохирсон орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ;
- ✚ Орон сууцны шинэ хоткон, хорооллын дэд бүтцийг байгуулахад хувийн хэвшлийн оролцоог санхүүгийн бодлогоор дэмжих.

ГАЗАР

18. “СЭТГЭЛТЭЙ МОНГОЛ” НИЙГМИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Уриа: Мэдлэгт сууринсан нийгэм ба ур чадвар бүхий монгол хүн төлөө

Үндсэн хуулинд заасан хувь хүний үндсэн эрхүүдийг амьдралд баталгаажуулах бодлого явуулна. Монгол хүний амьдралын стандартыг тогтоож, Монгол хүн Монгол газар нутагт нэгдүгээрт байхыг баталгаажуулна. Нэг ч Монгол хүнийг төрийн хамгаалалтын гадна байлгахгүй байх бодлогыг хэрэгжүүлнэ.

Нийгмийн халамжийн бодлого нь ажилгүйдэл, ядуурал, эмэгтэйчүүд, хүүхдүүд, ахмад настан, залуучуудын мэдлэг боловсрол эзэмших асуудал, иргэний хамгааллын асуудлыг шийдэхэд чиглүүлэн хэрэгжүүлнэ. Ид хийж бүтээх насандaa ажлаас халагдсан хүмүүсийн ажилгүйдэл, ядуурлын эсрэг бодлого ямар байх вэ? Эмэгтэйчүүд, хүүхдүүдэд чиглэсэн бодлого ямар байх вэ? Гавьяаныхаа амралтанд гарсан ахмадууд, мэдлэг боловсрол эзэмшиж буй залуучуудын бодлого ямар байх вэ? Монголын иргэнээ хамгаалах нийгмийн бодлого ямар байх вэ?

Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь жендерийн тэгш байдлыг хангах, бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцог бүрдүүлэх, зохицой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Зорилт 1. Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно.

-Ye шат 1- (2016-2020): Ядуурлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлж, иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан, хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлж, ядуурлын түвшинг 18 хувь хүртэл бууруулах.

Зорилт 2 . Үндэсний онцлог, хүн амын насын бүтцийн өөрчлөлтөд нийцүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцог хөгжүүлнэ.

-Ye шат 1-(2016-2020): Нийгмийн даатгалын (тэтгэврийн, үйлдвэрлэлийн ослын, ажилгүйдлийн, хөдөлмөр эрхлэлтийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн даатгал) тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлж, сангудын бие даасан байдал, удирдлага, засаглалыг сайжруулж, захиран зарцуулалт, санхүүгийн менежментийг ил тод

Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтолцоо

Зорилт 1. Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгана.

-Үе шат 1- (2016-2020): Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчилж, урьдчилан сэргийлэх, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлэх хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй зохион байгуулах, тандалт, эрт илрүүлэлтийн тогтолцоо, лавлагаа лабораторийг бэхжүүлж, хүн амын дундаж наслалтыг 71-д

МОНГОЛ УЛСЫН

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГА

УХА0122

Зорилт 2. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэл нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.

-Үе шат 1- (2016-2020): Эхийн эндэгдлийн түвшинг 100,000 амьд төрөлтөд 25, тав хүртэлх насын хүүхдийн эндэгдлийн түвшинг 1,000 амьд төрөлтөд 15, он 04 сар 12-

№ 803

Зорилт 3. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас барагтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.

-Үе шат 1- (2016-2020): Хүн амын хорт дадал, зуршлыг бууруулж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүнд чанар стандартыг чанд мөрдүүлэх, 10,000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас барагтыг 17.4, хорт хавдраас шалтгаалсан нас барагтыг 10.5 хүртэл бууруулах.

Зорилт 4. Халдварт өвчиний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакцинийг хүн бүрт хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчиний тархалтыг бууруулна.

-Үе шат 1- (2016-2020): Товлолт дархлаажуулалтын хамралтын хувийг 98.5, 10,000 хүн амд вируст хепатитын өвчлөлийг 3, сүрьеэгийн тохиолдлыг 14:4 болгон бууруулах. Үйлдвэрчний эвлэлтэй бүх талаар хамтран ажиллаж, цалин хөлс, тэтгэвэр тэтгээмжийг ДНБ-ний өсөлтийг жигнэж жил бүр нэмэгдүүлнэ.

Зорилт 1. Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшиүүлнэ.

-Үе шат 1: (2016-2020): Сургуулийн өмнөх боловсролын тогтолцооны төрөл хэлбэрийг өргөтгөж, хүртээмж, чанарыг сайжруулан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд нийт хүүхдийн 70 хувийг хамруулах нөхцөл бүрдүүлэх.

Зорилт 2. Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцуулэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулна.

Зорилт 3. Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд нийцүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог боловсронгуй болгож, төгсөгчдөд мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшиүүлнэ.

-Үе шат 1- (2016-2020): Нийгмийн түншлэл дээр үндэслэн мэргэжлийн боловсрол,

сургалтын багшлах боловсон хүчнийг чадваржуулж, техникийн баазыг өргөжүүлж,

суралцагчдын тоог 60.0 мянгад хүргэх.

Зорилт 4. Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгоно.

-Үе шат 1-(2016-2020): Сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн түншлэлд түшиглэсэн, олон улсын стандартад нийцсэн дээд боловсрол эзэмших шаталсан тогтолцоог бүрдүүлж, тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэх.

Зарчим баримтална.

Шударга байх

Хүртээмжтэй байх

Ялгаварлалгүй байх

Хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлт нь хүний хөгжил байх;

иргэний болон насан туршийн боловсролын тогтолцоо нь нээлттэй, хүртээмжтэй, чанартай байх;

Эрүүл мэндийн үйлчилгээ нь иргэн, хамт олон, нийгмийн тэгш оролцоонд тулгуурласан, чанартай, хүртээмжтэй, санхүүгийн эрсдэлээс хамгаалагдсан

байх;

Хөдөлмөрийн чадвартай хүн амын ажил эрхлэлтийн түвшинг хамгийн өндөр

түвшинд хүргэх чиглэл баримтлах;

нийгмийн хамгааллын үйлчилгээ нь баталгаатай, хүртээмжтэй, зорилтот бүлэгт чиглэсэн байх;

Нийгмийн үйлчилгээнд зарцуулж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтын

зардлыг хүн амын тоотой уялдуулж төлөвлөх;

Нийгмийн хөгжил дэвшилд жендерийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн

баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх;

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх.

ЗАР

жер

18.1. МОНГОЛ ХҮҮХДЭД ТОХИРСОН МОНГОЛ ХҮН ҮЗЛИЙГ БАГААС НЬ СУУЛГАНА.

Зөвшөөрөхгүй..,

Монгол хүүхдийг тоглох газаргүй, хүмүүжих орчингүй, зэнгөөрөө өсөхийг, өрөнд баригдсан ирээдүйтэй байхыг..,



Ингэж шийднэ.

Зорилтууд:

- Монгол хүүхдийг Монголын ирээдүй хэмээн хүндэтгэж, Монгол хүүхдэд тохирсон Монгол гэсэн сэтгэлгээг хөгжүүлэх залгамж үеийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- Монгол хүүхдийг хэвлийд байхаас нь төрийн хамгаалалтанд авч, Монгол ухаанаараа хүмүүжүүлэх шалгарсан аргуудыг хэрэгжүүлэн хэвшүүлэх, эрүүл саруул Монгол хүн болон хүмүүжих, боловсрох үндсэн суурийг бий болгож анхаарч ажиллана.
- Монгол хүүхэд бол Монгол үндэстний ирээдүй учир хайрлаж, хамгаалж өсгөх ёстой. Ирээдүйд Монгол улсаа авч явах боловсон хүчин учраас хамгийн орчин үеийн мэдлэг боловсрол эзэмшихэд шаардлагатай суурь мэдлэгүүдийг бүгдийг нь эзэмшүүлж, өндөр ёс суртахуунтай хүн болгон төлөвшүүлэхэд анхаарах болно.
- Монгол хүүхдэд зориулсан багаас нь хүмүүжил, иргэний боловсрол олгох “ЭЗЭН ХҮН 78/22” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж Монголын ирээдүйг багаас нь хөгжүүлнэ.

18.3. МОНГОЛ ОЮУТНЫГ ШУДАРГА ШАЛГУУРААР УЛСЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАХ ӨРСӨЛДӨӨНИЙГ БИЙ БОЛГОНО.

Зөвшөөрөхгүй.,

Оюутнуудыг сурах орчингүй, амьдралын баталгаа болохгүй мэдлэг боловсрол эзэмшүүлж, зах зээлд өрсөлдөх чадваргүй, хөрвөх чадваргүй бэлтгэж буйтай, төлбөртөө тэнцэх хэмжэний мэдлэгийг өгөөж өгөхгүй байгааг..

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН**

УХА0122

№ 803

20... он 04 сар 47

Ингэж шийднэ.

Зорилтууд:

- 4 Монгол оюутнуудыг Монгол үндэстний ирээдүйг авч явах учир өндөр ёс суртахуунтай, боловсон хүчин болгон бэлтгэхэд нийгмийн бодлого чиглэгдэнэ. Залуучуудын мэдлэг боловсрол ~~эзэмшигээр~~ сурч буйг ариун хөдөлмөрт тооцох ёстой. Улс, үндэстэн, эх орныхоо төлөө мэдлэг эзэмшин түүнийгээ эх орныхоо гэрэлт ирээдүйд зориулахаар суралцаж байгаа учраас хөдөлмөрлөж байгаад тооцох ёстой.
- 4 Их дээд сургуулиудыг орчин үеийн технологиор хийсэн эрдэм шинжилгээ, судалгааны иж бүрэн лаборатори, хамгийн багадаа 5 сая номтой номын сантай, багш оюутны амьдрах байртай сурах бүх бололцоог цогцоор нь шийдсэн хотхон хэлбэрт оруулах болно. Энэ бүх зардлыг Үндэстний Хөрөнгө Оруулалтын Сангаас хийх ёстой.
- 4 Улсын их дээд сургуулиудын Үндэстний боловсон хүчин бэлтгэх гол бааз гэж үзэн бодлогоор дэмжинэ. Монгол оюутныг тусгай зорилго өвертлүүлэн гадаадын их, дээд сургуульд сургаж, бэлтгэх замаар мэдлэгт суурилсан дэлхийг угтан хөгжих үйлдвэрлэлүүдийг хөгжүүлэх боловсон хүчинээ бэлдэнэ.

18.4. МОНГОЛ ЗАЛУУСЫГ ЧАДВАРЖУУЛАХ, МЭДЛЭГЖҮҮЛЭХ “МЭДЛЭГ-72/22” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.

Зөвшөөрөхгүй..,

Гадаадын их дээд сургууль эрх мэдэлтнүүдийн хүүхдүүд явдаг, эргэж ирдэггүй, төрийн зардлаар сурчихаад хувийн амьдралаа болгохын төлөө явагсад, бодлогогүй байдлыг..

Ингэж шийднэ.

Зорилтууд:

- 4 Монгол залуусыг Монголыг дахин хүчирхэгжүүлэхэд зүтгэх хүч хэмээн хүндэтгэж, тэднийг гадаадын нэр хүнд бүхий 100 их сургуулиуд, нарийн мэргэжлийн сургуулиудад тодорхой зорилго, тусгай гэрээний дагуу бэлтгэх, чадваржуулах, мэдлэгжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.
- 4 Тэднийг шинэ физик, шинэ биологи, шинэ математик, шинэ хими, шинэ сансар судлал, инженерчлэл, шинэ химийн инженерчлэл, шинэ механик инженерчлэл, шинэ электроникийн инженерчлэл, шинэ цахилгааны инженерчлэл, шинэ материалын инженерчлэл, шинэ сансрын инженерчлэл, шинэ биоинженерчлэл, шинэ наноинженерчлэл гэсэн нарийн мэргэжлүүдээр мэргэшүүлэн бэлтгэнэ.
- 4 Санхүүгийн, маркетингийн, менежментийн, борлуулалтын, хүний нөөцийн, мөнгөний, олон улсын капиталын зах зээл, философи, хэлний философи, оюуны философи, улс төрийн философи, эдийн засгийн философи, этикийн философи, шинжлэх ухааны философи, метафизикийн философи, хуулийн философи, улс төрийн шинжлэх ухаан, социологийн шинжлэх ухаан, хуулийн

шинжлэх ухаан гэх мэт холч хараатай бодлогоор боловсон хүчинээ зохион байгуулалтайгаар бэлтгэнэ.

ГАЗАР

18.5. ЗАЛУУ ГЭР БҮЛИЙГ БАЙРТАЙ БОЛОХОД НЬ ТӨРӨӨС ДЭМЖИХ ХУУЛИЙГ АНХЛАН САНААЧИЛЖ БАТЛУУЛНА.

Зөвшөөрөхгүй..,

Монгол залуу гэр бүлийн 20 жилийн хөдөлмөрийн хэлсийг 2-хон өрөө байранд төлж, банкны эзэнд хөдөлмөрөө өгөхийг, 100 сая төгрөгийн зээлийг 250 сая болгож ~~банкны~~ эзэнг баяжуулахыг..,

Ингэж шийднэ.

Зорилтууд:

- Монгол залуу хүн бүрийг гэр бүл болоход нь байраар хангаж төрөөс хариуцна. Монгол эх орныхоо төлөө ухаан бодлоо чилээх боломжийг олгоно. Залуу хүмүүсийг байрны төлөө амьдардаг биш Монгол үндэстний төлөө зүтгүүлэх боломжийг нээнэ.
- Зах зээлийн эдийн засагтай Сингапур, Норвеги зэрэг орны үнэ төлбөргүй орон сууцжуулах шилдэг туршлагыг үндэслэн үйлдвэрчний эвлэлтэй бүх талаар хамтран ажиллаж, үндэстний хөрөнгө оруулалтын сангудын орлогын тодорхой хувь тодорхой хувь хэмжээг иргэдийг төрөөс үнэ төлбөргүй орон сууцаар хангахад зориулна. Зөвхөн хэрэглээний төлбөрийг л иргэдээс авна.
- Монгол улсын иргэн 18 нас хүрсэн үед орон сууцтай болох боломжийг хуульчилж мөрдүүлнэ.

18.6. МОНГОЛ ГЭР БҮЛИЙГ ТАЙВАН, АЗ ЖАРГАЛТАЙ АМЬДРУУЛАХЫН ТУЛД ЗҮТГЭНЭ.

Зөвшөөрөхгүй..,

Эрүүл мэндийн үйлчилгээ хүрдэггүй эмнэлгийн үйлчилгээг, гэр бүлийг тайван, аюултгүй амьдрах боломжийг бий болгохгүй байгаа бодлогыг..,



Ингэж шийднэ.

Зорилтууд:

- Монгол гэр бүл тайван, сэтгэл зовнилгүй амьдрахыг Монгол улс сайн сайхан болох гэдгээр тодорхойлж, Монгол улсыг улс төр, нийгэм, эдийн засгийн гурвалсан бодлогоор хөгжүүлнэ.
- Монгол гэр бүлийн эрүүл амьдрах боломжийг дэлхийн эрүүл мэндийн стандартад нийцүүлэн, иргэдэд хүргэх эрүүл мэндийн үйлчилгээг урьдчилан сэргийлэх үйлчилгээнд тулгуурлан хэрэгжүүлнэ. Эрүүл мэндийн салбарыг тогтолцоогоор нь өөрчилнэ.
- Монгол гэр бүлийн орлого өндөр байх, чадвартай байх боломжийг хамтын зах зээлийн эдийн засгийг хэрэгжүүлэх замаар иргэнийг орлогжуулах алхмуудыг шат дараалан хэрэгжүүлнэ.
- Монгол хүний хүнсний хэрэглээнд онцгой анхаарч эрүүл мэндийн, хэрэглээний стандартыг тогтоох ажлыг эхлүүлнэ.

18.7 МОНГОЛ ЭМЭГТЭЙГ ЭХ ХҮНИЙ ҮҮРЭГТЭЭ ХОЁРГҮЙ СЭТГЭЛЭЭР ЗҮТГЭХИЙГ ДЭМЖИНЭ.

Зөвшөөрөхгүй..,

Монгол эх хүнийг гэр бүлээ авч явахын тулд хүнд хүчир хөдөлмер эрхлэх, эх хүний үндсэн үүргээ биелүүлэхгүй байгааг.,,

Ингэж шийднэ.

Зорилтууд:

- ✚ Монгол эмэгтэй хүнийг Монголын ирээдүйн хойчийг төрүүлж, өсгөн хүмүүжүүлэх ариун үүргийг нь хүндэтгэн жирэмслэхээс нь эхлээд төрөх, хүмүүжүүлэх, сурч боловсроход нь төрийн зүгээс эдийн засгийн болон баталгаат амьдралын бодлогыг хэрэгжүүлнэ.
- ✚ Зах зээлийн эдийн засагтай, ардчилсан тогтолцоотой Норвеги орны шилдэг туршлага дээр түшиглэн нярайлсан эхчүүдийн хүүхдээ асран хүмүүжүүлэх үйл хэргийг Монголын үүрд оршин тогтонохиin төлөөх ариун хөдөлмөр гэж үнэлнэ.
- ✚ Эхчүүдэд хүүхдээ цэцэрлэгийн насанд хүрэх хүртэл үндэстний дундаж цалинтай тэнцэх тэтгэвэр олгохыг үргэлжүүлнэ. Нярай хүүхдүүдэд өгөх тэтгэлгийг олгохыг үргэлжүүлнэ.
- ✚ Монгол эмэгтэй хүнийг Монголчууд олуулаа болох зорилгыг хэрэгжүүлэх үүднээс төр анхааралдаа авч, эрчүүдийн гэрээ авч авах үүргийг өндөржүүлж тэдэнд эдийн засгийн болон эх хүний үүргээ хоёрдмол сэтгэлгүйгээр зүтгэх итгэл үнэмшлийг бий болгож ажиллана.
- ✚ Эхийн хэвлэлийд бүрэлдэн тогтсон хүүхдийг амьд хэмээн үзэж abort хийлгэхийг хориглоно. Abortыг таслан зогсоох хувьсгал хийнэ.

18.8. ГАДААДАД АМЬДАРЧ БУЙ ИРГЭДИЙГ ТӨР ХАМГААЛНА.

Зөвшөөрөхгүй..,

Гадаадад амьдарч буй иргэдийг хүний оронд боолын хөдөлмөр эрхлэх, эх оронгүй мэт байх, сонгуульд санал өгөх боломжгүй байх, хаягдсан мэт байхыг..,

Ингэж шийднэ.

Зорилтууд:

- ✚ Монголоос бусад улсад аль ч хэлбэрээр ажиллаж амьдарч аялж яваа Монгол улсын иргэдэд зориулсан нийгмийн бодлогыг бас орхигдуулахгүй. Улс, үндэстэн оршин тогтонохиin үндэс нь иргэн гэдэг байр суурьнаас хандана.
- ✚ Монгол хүн гадны аль нэгэн улсад явж байгаад ямар нэгэн асуудалд орсон тохиолдолд Монголын төр иргэнийхээ төлөө ажиллах болно. Иргэнтэй холбогдсон зардлыг төрөөс даах болно. Аль ч оронд байгаагаас үл хамааран Монголын хууль иргэн дээрээ очиж үйлчилдэг болгоно.

18.9. ХӨДӨӨ АЖ АХҮЙН САЛБАРТ МАЛЧИД, ТАРИАЛАНЧДЫН ЭДИЙН ЗАСГИЙГ ӨСГӨХ ХУУЛИЙГ САНААЧЛАН БАТЛУУЛЖ МӨРДҮҮЛЭХИЙГ ЗОРИНО.

Зорилтууд:

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, сургийн бүтцийн зохистой харьцааг бүрдүүлж, мал, амьтны өвчиний тандалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлэн, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.

-Ye шат 1- (2016-2020): Нийт малын сургийн бүтцийг зохистой болгох, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас баталгаажуулсан худалдааны хорио цээр бүхий мал, амьтны өвчингүй статустай нутгийн хэмжээг нийт газар нутгийн 10-аас доoshgүй хувьд хүргэж, мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг хөрш орнуудын зах зээлд гаргах мал эмнэлгийн эрүүл ахуйн зохистой орчинг бүрдүүлж, үндэсний мал, амьтны эмнэлгийн тогтолцоог боловсронгуй болгох.

Хүн амын төвлөрөл, зах зээлийн эрэлтийг харгалзан эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГИ
УХААЛ122

No . 803

20.11.2016 On 04 Cap . 82

үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эд, бүтээгдэхүүний болтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлнэ.

-Ye шат 1- (2016-2020): Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт мал, амьтны эзлэхүүнийг 3 хувьд хүргэж, эрчимжсэн мал аж ахуйд цэвэр үүлдрийн үхрийн тоог 100.0 мянган толгойд хүргэх, гахай, тахианы аж ахуйн тоог нэмэгдүүлж, импортын хэмжээг бууруулан, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг аймаг, сумын түвшинд бий болгох.

Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникийн болон ~~мер~~ усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлнэ.

-Ye шат 1- (2016-2020): Үр тарианы үйлдвэрлэлийн талбайд тэг элдэншүүлэлтийн технологи нэвтрүүлэх ажлын явцыг 70 хувьд, усалгааны хэмнэлттэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, усалгаатай тариалангийн талбайг 65.0 мянган га-д, жилд шаардагдах бордооны хангамжийг 50 хувьд, нутагшсан сортын элит үрийн хангамжийг 75 хувьд тус тус хүргэн, тариаланд ашиглагдаж байгаа талбайн хөрсний шим тэжээлт чанарыг нэмэгдүүлж, элэгдэл эвдрэлийг сааруулах.

Малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бурдуулнэ.

-Ye шат 1- (2016-2020): Малчин, тариаланчдын 50 хүртэл хувийг өрхийн аж ахуй эрхлэхэд нь хүрэлцэхүйц чадалтай цахилгааны эх үүсвэр, техник, технологиор хангах, лизинг, хөнгөлөлттэй зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

Зешеөрөхгүй...

Монгол малыг төрийн хамгаалалтанд байна гэсэн үндсэн хуулийн заалт хэрэгжихэй байгааг, эрүүл ахуйн шаардлага хангахгүй, дэлхийн зах зээлд гаргах боломжгүй байгааг, малчид нийгмийн даатгалд хамраадахгүй байгааваа, малчин гэсэн тэмдээ, вэрчилгээээр хуурч байгааваа, малчдын нийгмийн баталгаагаа ханаж өөч чадахгүй байгааваа.,,

Хүн төрөлхтний хүнсний 80 хувь нь мал аж ахуйгаас гаралтай, мал аж ахуй нь газар тариалангаас 20 хувийн ашигтай байдгаас гадна олон наст таримал бэлчээртэй мал аж ахуйн бүтээмж нь өндөр байдаг.
Ингэж шийднэ.

Зорилтууд:

- ➊ Таримал бэлчээрт тулгуурласан мал аж ахуйгаар хөдөө аж ахуйн хөгжлийн гол чиг хандлага болгож, Монголын өрх бүр өөрийн таримал бэлчээрийн мал аж ахуйтай байхыг хуульчлан тогтоож төрийн хамгаалалтанд авна.
- ➋ Цэвэр газар тариалангийн салбар нь эдийн засгийн хувьд тарималжсан бэлчээртэй мал аж ахуйгаас хорин хувиар бага байdag гэдгийг олон улсын түвшинд баталсан бөгөөд Евроазийн бус нутаг нь экологийн хувьд хэврэг учраас цэвэр газар тариалан эрхлэх нь цөлжилт элжилтийг сүйрлийн хэмжээнд хүргэх аюултай тул Монгол улс дээрх хүчин зүйлээс үүдэж таримал бэлчээрийн мал аж ахуйг эрчимжүүлж тариалантай хослуулах.
- ➌ Малчдыг нийгмийн даатгалд хамруулж, тэтгэвэрт хамрагдах бололцоог хангах, эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй болгоно.

18.10. МОНГОЛ ӨНДӨР НАСТНЫГ ТӨРИЙН ХАМГААЛАЛТАД АВНА.

Зөвшөөрөхгүй...

Монголын ирээдүйг бүтээлцэж, насны тэтгэвэрт суусан ахмадуудыг амьдралд хүрэлцахгүй бага тэтгэвэр тогтоох, тэтгэвэрт гарангут төрийн анхаарал суларч зөнд нь орхиж буйг...

МОНГОЛ УЛСЫН

ҮНДЭСНИЙ АУДИТЫН I

УХА0122

№ 803

20 / 6 он 97 сар 82

Ингэж шийднэ.

Зорилтууд:

- ✚ Ахмадууд бол бүх залуу нас, бүх амьдрал, бүх эрч хүчээ улсдаа зориулсан хийх бүх юмаа хийчихээд гавьяаныхаа амралтанд гарсан амарч буй хүмүүс юм.
- ✚ Монголын ахмад өндөр настнуудыг төрийн хамгаалалтад авч, сэтгэл амар үр хүүхдээ хүмүүжүүлэх боломж орчныг бүрдүүлж өгнө. Монгол өндөр настанд зориулсан чөлөөт цагаа өнгөрөөх төвүүд, амралт, сувилал, эмнэлгүүдийг байгуулж үйлчилнэ.
- ✚ Тэтгэврийн ялгааг арилгаж, залгамж тэтгэвэрийн тогтолцоог хэрэгжүүлнэ..
- ✚ Гавьяаныхаа амралтанд гарсан ахмадууд хамгийн багадаа үндэстний дундаж цалингаас дээш байхаар тооцоолсон тийм хэмжээний тэтгэвэртэй байхаас гадна эм тариа, эмчилгээ гэх мэт эрүүл мэндийн бүх эмчилгээ үйлчилгээнд хүртээмжтэй хамрагдах орчинийг сайжруулсан , ахмадууд хүсвэл хэзээ ч очиж болдог, байгалийн үзэсгэлэнт газар, орчин үеийн технологиор тоноглогдсон бие чийрэгжүүлэлт, эрүүл мэндийн үйлчилгээ, асаргаа сувилгааны бүтэн цогц үйлчилгээтэй асрамжийн газруудыг байгуулах хуулийн төслийн санаачилж батлуулна.
- ✚ Ахмадуудад зориулсан нийгмийн бодлогыг хэзээ ч орхигдуулахгүй.

18.11. МОНГОЛ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ ХАМГААЛНА.

Зөвшөөрөхгүй..

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилдэг газаргүй байлгаж буйг, нийгмээс гадуур үзэж буй явдлыг, тэднийг энгийн хүн мэт амьдрах ахуйн болон хөдөлмөр эрхлэх боломжийг бий болохгүй байгааг...

Ингэж шийднэ.

Зорилтууд:

- ✚ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг онцгой анхаарч, тэднийг энгийн хүн шиг амьдрах баталгаа бий болгоно.
- ✚ Гудамж талбай, байшин барилга, орц, зам зэрэгт тэдэнд зориулсан гарц замуудыг стандартчлан тогтоож мөрдүүлнэ. Оюутан суралцагч нартай харилцан гэрээ байгуулж хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцан туслалцах байдлаар аж төрөх боломжийг бүрүүлнэ.

19. "САХИЛГАТАЙ МОНГОЛ" УЛС ТӨРИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Дэлхийн хараатай улс төрийн бодлого явуулна. Монгол үндэстний аагтай хүсэлд хэн ч хориг болж үл чадна. Монгол улсыг дэлхийн G-20 улсын жагсаалтад дээгүүр байр эзлүүлэх холч, амбицтай бодлого явуулна., Монгол хүний хамгийн том хүсэл улс төрийн амбицаар илрэх ёстой..,

Зарчим баримтална.

Үндэстний эрх ашиг нэгдүгээрт байх

Хүчирхэг байх

Шударга байх

Харгүй байх

Тэгш байх

Эрх чөлөөтэй байх

Оюун санааны дархлаатай байх

19.1. УЛС ТӨРИЙГ ЗАСАХ БОДЛОГО

АЗАР

Зөвшөөрөхгүй..

Төрд бизнес хийх гэж орж ирэгсэд, тендер нэрээр хөлжигсөд, өмч хувьчлал нэрээр баяжсан хумүүс, татвар төлөгчдийн мэнгөөр туйлагсад, дотоодын валютыг гадаадад хүүлэгчид, газрын баялагийг гадныханд тал засан хямд зарагсад, албан тушаалын төлөө амь тавигч нарыг..,

Ингэж засна:

- ✚ Төрөөс төрсөн тэрбумтан гэж нэрлэгдэж, сэжиглэгдэж байгаа бүх хүмүүсийг ялгаварлан гадуурхахгүйгээр шүүхэд өгч үнэн худлыг нь шалгуулж засах анхдагч бодлого явуулна.
- ✚ Төрийн эрх мэдлийг ашиглаж өөрийн төлөө, өөрийн гэр бүл, хамаатан садан, хамсаатанг хөрөнгөжүүлэх зорилгоор төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжийг шамшигдуулдаг хэлбэрээр илэрч байгаа олигархийн тогтолцоо нь Монгол үндэстэн цаашлаад хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг төдийгүй нийт ард түмний сайн сайхан амьдрах боломжийг хааж байгаа тул олигархиудыг Монголын улс төрөөс цэвэрлэх бодлого явуулна.
- ✚ Монгол үндэстний эсрэг оюуны терроризмыг бүрэн таслан зогсоох зорилгоор мухар сүсэг, худал мэдлэг, дутуу мэдлэг, алдаатай мэдлэгээр ард түмний толгойг угаадаг бүх үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор оюуны терроризмтай тэмцэх үндэстний бодлогыг хэрэгжүүлнэ.
- ✚ Ардчилсан орнуудын засгийн газрууд, олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, гадаад дотоодод байгаа олигархиудын үл хөдлөх хөрөнгө, хувьцаа болон хадгаламжийг олон нийтэд ил тод болгох бодлого баримтална.
- ✚ Олигархиудын гар хөл болсон оюуны терроризм явуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагууд, олон нийтийн байгууллагуудыг хуулийн хариуцлага хүлээлгэх бодлого барина.
- ✚ Монголын ард түмний баялагийг зохион байгуулалттайгаар тонон дээрэмдэж, мөнгө угааж байгаа гэмт хэргийг таслан зогсоож, хуулийн хариуцлага хүлээлгэж, хар жагсаалтад мөнхөлнэ. Дэлхийн улс үндэстэнд гадуурхагдаж буй Монголын арчаагүй бодлогыг засаж запруулна.
- ✚ Үзэл баримтлал тодорхойгүй, давхацсан үзэл баримтлалтай намуудыг тарааж, татан буулгаж улс төрийн хуваарилалтыг дэлхийн жишгийн дагуу дахин зохион байгуулах.
- ✚ УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн байхыг хориглож, хуульчлан хэрэгжүүлнэ.

19.2. УЛС ТӨРИЙН ХҮЧТЭЙ БАЙХ БОДЛОГО

Ингэж шийднэ.

Зорилтууд:

- ✚ Нэг ч Монгол хүнийг төрийн хамгаалалтын гадна байлгахгүй байх, Монгол хүн бүр эдийн засгийн өгөөжийг тэгш хүртэх шударга зарчмыг хэрэгжүүлнэ.
- ✚ Аливаа улс орон хөгжлийн хөтөлбөрөө боловсруулахдаа өөрийн онцлогтоо тохирсон улс төрийн идеологи дээр суурилдаг. Монгол улс даяарчлагдсан ирээдүйд дэлхийн олон улсад чиглэсэн улс төрийн идеологиор Монголын онцлогт консерватив идеологийг хэрэгжүүлнэ.
- ✚ Даяарчлагдсан ирээдүйд Монголын консервативизм нь дэлхийн бусад улс оронтой явуулах улс төрийн үзэл баримтлал байх ёстой. Даяарчлагдсан орчин үеийн дэлхийн тогтолцоог үндэслэгч.

- МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗ
№ 803
20/04/2016 ОУ САР 02
- Монгол үндэстэн улс дамнасан улс төр, эдийн засаг болон нийгмийн тогтолцоогоо сэргээн босгож, бодитой болгох зорилго бүхий төрийн тогтолцоог буй болгох хүчтэй бодлого баримтална.
 - Аливаа зүйл зөв байх ёстой гэсэн зөвийн тухай ухагдахууныг улс УХА0122 төр, эдийн засаг, нийгмийн бүх салбарт сэргээн хэрэглэж, ардчиллын үнэт зүйлсүүдийг жинхэнэ утгаар амьдралд нэвтрүүлж, Монгол оронд шударга хөдөлмөр эрхлэж байгаа гадаадын байгууллага болон иргэдийг авилгачдаас хамгаалах.
 - Бүх улс төрийн хүчин, иргэний байгууллага болон төрийн бус байгууллагатай Монгол үндэстний эрх ашгийн төлөө хамтран ажиллана. Нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгийн төлөө нийгмийг цогцлоон байгуулна.
 - Монгол улсын хар хайрцагны бодлогыг мэдлэг болон эрдэм гэж тодорхойлж, үүнийг даяарчилсан улс төр, эдийн засаг, нийгмийн бүх цар хүрээнд институцилэн хэрэгжүүлнэ.
 - Ардчилалыг хамтын Ардчилалд шилжүүлэх "САХИЛГАТАЙ МОНГОЛ" АРДЧИЛАЛЫГ ЗАСАХ ХУВЬСГАЛ өхлүүлнэ. Ингэж хэрэгжүүлэхдээ нэг ч Монгол хүний эрх чөлөө, тэнцүү эрх, шударга ёс болон андын харилцааны гадуур орхигдуулахгүй.
 - Монгол үндэстэн дахин хүчирхэгжиж их үйл хэргийг Монгол хүний хамтын оюун, мэдлэгээр хэрэгжүүлнэ. Монгол үндэстэн дэлхийн хүн төрөлхтнийг авч явах хариуцлагатай үүргээ гүйцэтгэхэд Монгол хүний төрөлхийн оюун ухаан, мэдлэгт турлуурлан хэрэгжүүлнэ. Монгол Үндэстний нэгдэн нягтрах Монгол бодлогыг эрчимтэйгээр явуулж, Монгол хүн бүрийг Монгол нутагтаа эргэн ирэх, иргэнших, амьдарч, ажиллах боломжийг Монгол төрийн олуулаа болох бодлогоор хэрэгжүүлнэ.
 - Монгол хүмүүсийн хамтран оюун санаагаа нэгтгэх, мэдлэгээ хуваалцах, хамтран үндэсний болон үндэстэн дамнасан байгууллагууд байгуулахыг хөхиүлэн дэмжинэ.
 - Даяарчлагдсан дэлхийд Монгол хүний мэдлэгийн хүчээр улс төрийн далайцтай бодлогыг хэрэгжүүлнэ. Түүх давтагдаг гэхдээ түүхийг давтах нөхцөлийг бүрдүүлсэн төрийн бодлого, ард түмэн байсан цагт л түүх давтагдаг юм. Монгол үндэстэн даяарчлагдсан ирээдүйд Монголын онцлогт консервативизмыг хэрэгжүүлэх нь Монгол үндэстний дахин босч ирж хүн төрөлхтний хувь заяаг шийдвэрлэх хариуцлагатай байрандаа эргэн ирэх боломж юм.

"Сахилгатай Монгол" улс төрийн бодлогын хувьсгалын хүрээнд зүйн шинэтгэлийн зарчмын үндэслэлүүдийг дараахь 7 үндсэн чиглэлээр хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын бүрэн эрхт байдлыг хангах эрх зүйн үндсийг төгөлдөржүүлэх;
- Эдийн засгийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох;
- Хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангах;
- Төрийн байгууллын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох;
- Эрх зүйн шинэтгэлийн орчин бүрдүүлэх;
- Хууль зүйн мэргэжлийн боловсон хүчний сургалтын тогтолцоог боловсронгуй болгох;
- Олон улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын оролцоог ергөтгөх.

Тухайлбал:

- Үндсэн хуулийг өөрчлөлт оруулах
- Цаазын ялыг сэргээх хууль батлуулах
- Гадаадад хөрөнгө, дансгүй байх тухай хуулийг батлуулах
- Хувийн мөрдлөгийн тухай хуулийг батлуулах
- Улс төрийн намуудын тухай хуулийг батлуулах

- Хандив тусламжийн тухай хууль
- Гаалийн хөнгөлөлт татварын тухай хууль
- Импортын татварын тухай
- Татвар өгсөн иргэдийн хөнгөлөлтийн хууль
- Абортыг хориглосон хууль батлуулах

AP

20. “САРУУЛ МОНГОЛ” ТӨРИЙН ДЭЭД ХҮН БЭЛТГЭХ БОДЛОГО

Дэлхийг харж, сэтгэдэг хүмүүсийг тусгай сургалтаар дамжуулан бэлтгэх, Монголын ирээдүйн төлөө зүтгэх шинэ үеийн хүчинг бэлтгэнэ. Дэлхийн хэмжээний бодлого боловсруулах хүмүүсийг тусгайллан хангаж зүтгүүлнэ. Харийн шашинд мөргөж, харь хүнийг шүтсэн хүн Монгол төрийг хэзээ ч удирдаж чадахгүй...

цир

Зарчим баримтална

Ухамсартай байх
Эрдэмтэй байх
Мэдлэгтэй байх
Хүчирхэг байх
Шударга байх
Эрх чөлөөтэй байх
Оюун санааны дархлаатай байх

20.1. МОНГОЛЫН ИРЭЭДҮЙГ БЭЛТГЭНЭ.

Зөшөөрөхгүй..

Төрийн зардлаар сураад амиа хоохойлон амьдрагсдыг, татвар төлөгчдийн мөнгөөр суралцаад юу ч сурдаггүй мэдлэггүйчүүдийг, үндэсний эрх ашгаас өмнө амин хувия боддог бэртэгчингүүдийн, татаасаар дээшээ гарч юу хийхээ мэдэхгүй ажил алагсдыг, мэдлэггүй хирнээ мэдлэгтэй хүний дүрд тоглогч нарыг, ард түмэнд үйлчлэхээ умартан ард түмнийг тамлан зовооч хурган дарга нарын үйлдлийг...

Ингэж шийднэ. Монгол залуусыг Монголыг дахин хүчирхэгжүүлэхэд зүтгэх хүч хэмээн хүндэтгэж, тэднийг гадаадын нэр хүнд бүхий 100 их сургуулиуд, нарийн мэргэжлийн сургуулиудад тодорхой зорилго, тусгай гэрээний дагуу бэлтгэх, чадваржуулах, мэдлэгжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

Монголын залуучуудад зориулсан үндэсний үзлийг тусгасан тусгай хөтөлбөр боловсруулан төрийн дээд хүн бэлтгэх “ДЭЭД ХҮН-78/22” Үндэсний хэмжээний хөтөлбөрийг боловсруулж вакумжуулсан сургалт хэлбэрээр зохион байгуулна.

“ДЭЭД ХҮН-78/22” Үндэсний хэмжээний хөтөлбөрийн хүрээнд төрийн хүн бэлтгэх төв их сургуулийг байгуулах, Төрийн хар хайрцагны бодлого боловсруулагч үндэсний нууц бодлогын хүрээлэн байгуулах, эх оронч үзлийг алхам тутамд шингээсэн институтчилсан сүлжээг бий болгоно.

Монгол үндэстний залуучуудыг төлөвшүүлэн, бэлтгэх зорилгоор “МОНГОЛЫН ЗАЛГАМЖ ҮЕ-78/22” олон улсын статустай төрийн бус байгууллагыг зохион байгуулалтанд оруулж, салбарууд байгуулж ажиллуулна. Тус байгууллагын дэргэд сургалт, хүмүүжлийн их сургуулийг байгуулна.

Ахмадуудад зориулан үндэсний хэмжээний “ӨВЛӨХ ЭРДЭМ-78/22” хөтөлбөрийг боловсруулж ахмадын захиасыг хэрэгжүүлэх “ӨВЛӨХ ЭРДЭМ” бодлогын төвийг байгуулж ажиллуулна.

**МОНГОЛ УЛС ТУНГАЛАГ ТӨРТЭЙ БОЛЖ,
САЙХАН МОНГОЛ БОЛОХЫН ЕРӨӨЛ ӨРГӨЕ.**

-----оо-----

ТАЛАРХАЛ,

Энэхүү **БОДЛОГЫН ХУВЬСГАЛ -(5+3)** баримт бичгийг мэдлэгтэй хүмүүс, эрдэмд **УХА0122** нэвтэрсэн буурлууд, эрдэмтэд, шинэ үеийн эх оронч залуусын дэмжлэгээр олон жилийн улс төр, нийгэм, эдийн засгийн судалгаа, онолын болон практик эх сурвалж, түүхийн чанэт бичгүүдэд тулгуурлан бүтээв. Энэ эх бичгийг бүтээхэд тусалсан хүмүүст талархал илэрхийлье. Энэхүү эх бичиг хамтын бүтээл бөгөөд нарийвчилсан төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрүүд болон хэрэгжих болно.

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГА**

**№ 803
2016 он 04 сар 07**

МОНГОЛ КОНСЕРВАТИВ НАМЫН ДАРГА Н.ДАШДАВАА
2016 оны 04 сарын 12-ны өдөр

Намын албан ёсны цахим хаяг:

Website: www.mcparty.mn
Facebook: @mcparty2016
Twitter: @mconservativep
E-mail: mconservativeparty@gmail.com
info@mcparty.mn
Төв шуудан 2429
Шуудангийн хайрцаг:

Хол барих утас:

Утас: +976-11-88197752, +976-11-94042016

Намын даргын цахим хаяг:

Twitter: @dashka2016
Facebook: @dashdavaa2020
Page: @dashdavaa2016
E-mail: dashka2016@yahoo.com



Ашиглах материалууд

- www.google.com (For example Economy of the United States)
- www.bloomberg.com
- www.worldeconomicforum.com
- www.oecd.org and OECD Economic Survey of the USA
- CIA- The World Factbook-nited States (www.cia.gov)
- Gross Domestic Product Growth- USA (www.euroekonom.com)
- www.imf.org
- www.worldeconomicforum.com
- www.bis.org
- De Soto Hernando.2000. The mystery of capital.New York: Bantam Press.
- Global Development Finance.2011. Review, Analysis and Outlook. World Bank, Bashington D.C.
- IMF: World Economic Outlook, 2011.
- www.worldbank.com
- www.asiandevelopmentbank.com
- www.worldeconomiccondition.com
- www.economyoftheworldcountries.com
- www.iltod.gov.mn
- www.mof.gov.mn (Сангийн яам)
- www.mta.mn -Татварын ерөнхий газар
- www.ecustoms.mn -Гаалийн ерөнхий газар
- www.e-procurement.mn -Засгийн газрын худалдан авах үйл ажиллагаа.mn
- www.monicpa.mn -Мэргэшсэн нягтлан бодогчдын институт
- www.mca.mn - Мянганы сорилын сан
- www.meforum.mn -Монголын эдийн засгийн форум
- Mongolbank.mn
- Khanbank.mn
- Savingsbank.mn
- Developmentbank.mn
- DevelopmentTradebank.mn
- Монгол улсын үндэсний хөгжлийн цогц бодлого-2008
- Монгол улсын санхүүгийн хөгжлийн хөтөлбөр
- Монгол улсын санхүүгийн хуулиуд.
- Монгол улсын 2009-2011 оны төсвийн төсөл
- Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт-2007
- Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тойм(2004-2007, 2008 оноос хойшхи судалгаа)
- www.ndic.gov.mn (Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо)

САЙТУУД

- www.imf.org
- www.bis.org
- www.oecd.org - and OECD Economic Survey of the USA
- www.google.com - For example Economy of the United States
- www.bloomberg.com
- www.worldeconomicforum.com
- www.cia.gov - CIA- The World Factbook-nited States ()
- www.euroekonom.com - Gross Domestic Product Growth- USA
- www.worldbank.com
- www.asiandevelopmentbank.com
- www.worldeconomiccondition.com
- www.economyoftheworldcountries.com
- www.iltod.gov.mn
- www.mof.gov.mn - Сангийн яам
- www.mta.mn -Татварын ерөнхий газар
- www.ecustoms.mn - Гаалийн ерөнхий газар

ЗАР

ЧЕР



- www.e-procurement.mn - Засгийн газрын худалдан авах үйл ажиллагаа тп.
- www.monicpa.mn - Мэргэшсэн нягтлан бодогчдын институт
- www.mca.mn - Мянганы сорилын сан
- www.meforum.mn - Монголын эдийн засгийн форум
- www.ndic.gov.mn - Үндэсний хөгжил, шинэ тгэлийн хороо

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

УХА0122

№ 803

20 / 16 он 04 сар 27 өдөр

ХЭВЛЭМЭЛ МАТЕРИАЛУУД

- De Soto Hernando. 2000, The mystery of capital, New York: Bantam Press.
- Global Development Finance, 2011, Review, Analysis and Outlook, World Bank, Bashington D.C.
- IMF: World Economic Outlook, 2011.
- Монгол улсын үндэсний хөгжлийн цогц бодлого-2008
- Монгол улсын санхүүгийн хөгжлийн хөтөлбөр
- Монгол улсын санхүүгийн хуулиуд.
- Монгол улсын 2009-2011 оны төсвийн төсөл
- Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт-2007
- Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тойм (2004-2007, 2008 оноос хойшх судалгаа)





СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНД

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2016. 04. 27 № 803

таний _____ -ны № _____ -т

Нийцлийн талаарх дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцоо бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа Монгол Консерватив намын "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-т Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянаж дүгнэлт гаргав.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Сонгуулийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах хариуцлага хүлээнэ.

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд намын боловсруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөр Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцэж буй эсэх талаарх дүгнэлтийг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасан хугацаанд Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх үүрэгтэй.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар УИХ-ын ээлжит сонгуульд оролцох Монгол Консерватив намаас ирүүлсэн "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-ийг Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт-4000, Төрийн хяналт шалгалтын стандартыг удирдлага болгон Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн дүгнэлт гаргав.

Дүгнэлт

Монгол Консерватив намын Сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуультай нийцсэн болно.

Хувийг: Монгол Консерватив нам

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД



\10.10.10.2015ichig_Khereg\Yawsan_Bichig\2016\0425NAG97.Docx

073797

000049